

**АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛ,  
ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР, ХЭЛТЭС, АГЕНТЛАГ,  
СУМДЫН 2023 ОНЫ 09 ДҮГЭЭР САРЫН АЖЛЫН МЭДЭЭ**

2023.10.04

Сүхбаатар сум

**Нэг. Удирдлага, зохион байгуулалтын хүрээнд:**

**Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын үйл ажиллагааны талаар:**

Хууль зүй дотоод хэргийн яам, Азийн хөгжлийн банкнаас хамтран “G9198/G9221-MON: Хүүхэд, эмэгтэйчүүдийн эсрэг гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх төсөл”-ийг хэрэгжүүлэгчидтэй уулзалт хийж, манай аймагт байгуулсан түр хамгаалах байрны үйл ажиллагааны талаар харилцан санал солилцлоо. Мөн эмэгтэйчүүдийн эдийн засгийн чадавхыг дэмжих бичил тэтгэлэгт төслийн үр шимийг хүртэгчидтэй уулзалт зохион байгуулж ярилцлаа. Төслийн багийнхан Сэлэнгэ аймагт ажиллах үеэрээ аймгийн Цагдаагийн газар, Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газрын холбогдох албан хаагчидтай уулзаж төслийн хэрэгжилт, үр дүнгийн талаар уулзалт хийлээ.

Мөн 9 дүгээр сарын 28,29-ний өдрүүдэд аймгийн Хамтарсан багийн гишүүдийн чадавхыг бэхжүүлэх сургалтыг зохион байгуулж, хамтарсан багуудад нэгдсэн арга зүй, аргачлалын дагуу үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлэх, улмаар гэр бүлийн хүчирхийллийг бууруулах үндсэн зорилгоор зохион байгуулсан.

Тус сургалтад хүүхэд, эмэгтэйчүүдийн эсрэг гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэн, зохих үйлчилгээ үзүүлдэг Хамтарсан багийн 240 гишүүд ажилладгаас 2 өдрийн сургалтад 150 гаруй гишүүд хамрагдсанаас эхний өдрийн сургалтад сумдын Засаг дарга, багийн Засаг дарга нар, багийн нийгмийн ажилтан, хэсгийн ахлагч нар суралцсан бол 2 дахь өдрийн сургалтад эмч, цагдаагийн алба хаагч, сургуулийн нийгмийн ажилтан, сэтгэлзүйч, халамж, нийгмийн ажилтан нар оролцлоо.

Сэлэнгэ аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга бөгөөд аймгийн Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөлийн дарга Б.Нарантуяа хилийн 0101 дүгээр ангийн захирагч, хурандаа Н.Баяржаргал болон хилийн 0243 дугаар ангийн захирагч, хурандаа Д.Ганхуяг нарыг хүлээн авч уулзаж хил хамгаалах байгууллагын үйл ажиллагааны талаар болон гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах чиглэлийн хамтын ажиллагааны талаар мөн цаашдын анхаарах асуудлуудын хүрээнд санал солилцлоо.

**Аймгийн Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагааны талаар:**

9 дүгээр сарын 02-ны өдөр Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлигаар төрийн дээд одон медалиар шагнагдсан иргэд, албан хаагчдад шагнал гардуулах арга хэмжээг зохион байгууллаа. Тус арга хэмжээнд “Хөдөлмөрийн гавьяаны улаан тугийн одон”-оор 5 иргэн, “Цэргийн гавьяаны улаан тугийн одон”-оор 1 иргэн, “Алтнгадас одон”-оор 17 иргэн, “Хөдөлмөрийн хүндэт медаль”-иар 4 иргэн, “Автотээврийн тэргүүний ажилтан”-аар 2 иргэн тус тус шагналаа гардан авсан.

Төрийн захиргааны гүйцэтгэх албан тушаалын сул орон тоог нөхөх зорилгоор 14 ажлын байран дээр төрийн албан хаагчийг шилжүүлэх, сэлгэн ажиллуулах зарыг байршуулсан. Мөн төрийн жинхэнэ алба хаах хүсэлтэй иргэнийг сонгон шалгаруулж, төрийн албан хаагчийн нөөц бүрдүүлэх зорилготой 3 дугаар улирлын ерөнхий шалгалтад 122 иргэн бүртгүүлснээс 91 иргэн хамрагдаж, ирц 74.59 хувьтай зохион байгуулагдаж, 44 иргэн тэнцэж нөөцөд бүртгэгдэх боломжтой боллоо.

АНУ-ын Хөдөө аж ахуйн яамны судалгааны багийн төлөөлөл 9 дүгээр сарын 6,7-ны өдрүүдэд газар тариалангийн бүс нутагтай танилцсан бөгөөд аймгийн

удирдлагуудтай хийсэн уулзалтын үеэр хөдөө аж ахуйн үйлдвэрлэл, хөрсний үржил шим, эрчимжсэн аж ахуйн асуудлуудаар талууд харилцан байр сууриа илэрхийлж, хамтран ажиллах боломжийн талаар санал солилцсон.

Мөн 2016 оноос хойш хөдөө аж ахуйн салбарт хамтын ажиллагаатай ажиллаж буй Япон улсын Шизуоко мужийн "Озова тент" компанийн төлөөллөлтэй УИХ-ын гишүүн Ч.Ундрам, болон орон нутгийн удирдлагууд хүлээн авч уулзан зоорь, хүлэмжийн чиглэлээр хамтран ажиллах санал солилцож, суурь судалгааны ажлуудыг эхлүүлэхээр тохиролцлоо.

Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүх "Хүнсний хангамж, аюулгүй байдал" үндэсний хөдөлгөөний хүрээнд 9 дүгээр сарын 8,9-ний өдрүүдэд манай аймагт ажиллаж Мандал суманд үйл ажиллагаа явуулдаг "АПУ Дэйри" компанийн бяслагны үйлдвэр, Цагааннуур сумын газар тариалангийн компаниудтай уулзалт хийж, 29-ний өдөр Баянгол сумын хүлэмжийн аж ахуй эрхлэгч "Бялхам ивээлт" ХХК, Баруунбүрэн сумын газар тариалангийн компаниудтай уулзалт хийж ургац хураалтын төлөв байдалтай танилцаа.

Мөн Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнээр ахлуулсан ажлын хэсэг 9 дүгээр сарын 15,16-ны өдрүүдэд Сэлэнгэ аймагт ажиллаж, ард иргэдтэй хийсэн уулзалтын үеэр Засгийн газраас хэрэгжүүлж буй "Шинэ сэргэлтийн бодлого"-ыг танилцуулж, санал, хүсэлтийг сонсож шуурхай шийдвэрлэж ажиллалаа. Айлчлалын үеэр "Сэлэнгэ Алтан намар-2023" үзэсгэлэн худалдаанд оролцох, Алтанбулаг боомтын "Ачаа тээврийн шалган нэвтрүүлэх барилга байгууламж"-ийн явцтай танилцах, аймгийн төв Сүхбаатар хотод 50МВт-ын цахилгаан станц барих бүтээн байгуулалтын ажлын шав тавих ёслолын үйл ажиллагаанд оролцох, Зүүнбүрэн сумын "Гэгээлэг трейд" ХХК, Цагааннуур сумын "Атар трейд" ХХК-иудын ургац хураалтын явцтай танилцах зэрэг томоохон ажлууд хийгдлээ.

Аймгийн төв Сүхбаатар сумын А зэрэглэлийн бүс насжилт өндөртэй барилга байгууламжийг дахин төлөвлөлтөд оруулах ажлын хүрээнд 7-р багт байрлалтай 2 блок бүхий 16 айлын орон сууцыг буулгаж 336 айлын орон сууц бүхий "Сүлд" хотхон байгуулах бүтээн байгуулалтын шав тавих ёслолын үйл ажиллагаа 9 дүгээр сарын 10-ны өдөр болж иргэдэд тав тухтай орчинд амьдрах боломж нэмэгдэж эхэллээ.

Төв, орон нутгийн нийгмийн даатгалын байгууллагын байцаагч, албан хаагчдад нийгмийн даатгалын багц хуулийн шинэчлэлийн талаар нэгдсэн ойлголт өгч чадавхжуулах, ажил олгогч даатгуулагчдад нийгмийн даатгалын хууль тогтоомжийн талаар мэдээлэл, танилцуулга хийх үндсэн зорилго бүхий сургалтыг манай аймагт зохион байгууллаа.

#### **Стандарт, хэмжилзүйн ажил үйлчилгээний талаар:**

Стандарт хэмжил зүйн салбарын 100 жилийн ойн арга хэмжээний хүрээнд Улаанбаатар хотод зохион байгуулагдсан "Иргэдэд ээлтэй стандарт өдөрлөг"-т албан хаагчдын төлөөлөл болон орон нутгийн брэнд бүтээгдэхүүн үйлдвэрлэгчдийн төлөөлөл оролцлоо.

Сүхбаатар сумын ЗДТГ-тай хамтран батлагдсан удирдамжийн дагуу худалдаа үйлчилгээний газруудын гадна, дотор тохижилт, өнгө үзэмжийг сайжруулах чиглэлээр 42 аж ахуйн нэгжийн үйл ажиллагаанд хяналт шалгалт хийн, зөвлөн туслах үйлчилгээ үзүүллээ.

Сүхбаатар, Баянгол, Сайхан сумын 7 иргэн, аж ахуйн нэгжийн 8 үйлчилгээний газрын үйл ажиллагаанд тохирлын үнэлгээ хийж, "MNS 5021-1:2019 Жижиглэн худалдааны газар, түүний үйлчилгээ. Ерөнхий шаардлага", "MNS 4946:2019 Хоол үйлдвэрлэл, үйлчилгээний газарт тавих шаардлага", стандартын шаардлагад нийцсэн 8 үйлчилгээний газарт баталгаажуулалтын салбар зөвлөлийн хурлын шийдвэрийг үндэслэж тохирлын гэрчилгээ олгосон.

Ерөө суманд “Болдтөмөр Ерөө гол” ХХК, “Инфинити спэйс” ХХК хэмээх 2 аж ахуй нэгжийн олборлодог “Металлургид хэрэглэх төмрийн хүдэрт тавих ерөнхий шаардлага ба төмрийн хүдрийг орлох түүхий материалын ангилал- MNS 6249:2011” стандартын шаардлагад нийцсэн төмрийн хүдрийн 76 удаагийн тээвэрлэлтэнд баталгаажуулалт хийж, экспортын гэрчилгээ олгосон байна.

Итгэмжлэгдсэн лаборатори нь тайлант хугацаанд нийт 72 аж ахуй нэгжийн 190 дээжинд 370 үзүүлэлтээр шинжилгээ хийсэн байна.

#### **Онцгой байдлын ажил үйлчилгээний талаар:**

Тайлангийн хугацаанд объектын гал түймрийн 5, эрэн хайх, аврах ажиллагаа 1, усны осол 1, авто осол 2 нийт 9 удаагийн гамшиг осол, гал түймрийн дуудлагаар иргэн, аж, ахуйн нэгж байгууллагын 60 сая төгрөгийн өмч хөрөнгийг авран хамгаалж ажиллалаа.

Хөдөлгөөнт болон завьт эргүүлийг Сүхбаатар, Мандал, Сайхан, Баянгол, Хүдэр сумдад хийж, амарч зугаалж буй 14,144 иргэдэд сэрэмжлүүлэг мэдээллийн шинжтэй 10,587 тараах материал тараан ажилласан.

Аймгийн нутаг дэвсгэрээр урсан өнгөрдөг Сэлэнгэ, Хараа, Ерөө, Орхон гол, Гүннуурын эрэг дагуу мөн хүн олноор цугларч амарч усанд ордог газруудад үерийн аюул, усны ослоос урьдчилан сэргийлэх сэрэмжлүүлгийн 36 ширхэг самбар шинээр байршуулж, хуучирч муудсан 5 самбарын тэмдэг тэмдэглэгээг сэргээн засварласан.

Монгол Улсын Шадар сайдын баталсан “Гэр хорооллын айл өрхүүдийн гал түймрийн аюулгүй байдал, урьдчилан сэргийлэх арга хэмжээ”-ний удирдамж, Онцгой байдлын ерөнхий газрын Урьдчилан сэргийлэх газрын даргын 2023 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн 10/1112 дугаар албан бичгийн хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд удирдамж боловсруулан 5 дугаар сарын 12-ны өдрөөс 9 дүгээр сарын 27-ны өдрийн хооронд хэрэгжилтийг ханган ажиллаж холбогдох мэдээллийг орон нутгийн “Сэлэнгийн мэдээ” сонинд байршуулж 17 сум, 6 тосгонд 800 ширхэгийг иргэдэд хүргэж ажиллалаа.

Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдыг аюулт үзэгдэл, ослоос урьдчилан сэргийлэх, аврах, өөртөө болон бусдад анхны тусламж үзүүлэхэд сурган дадлагажуулах, тэдний тэсвэр хатуужил, авхаалж самбааг сорих, хүнлэг энэрэнгүй иргэн болгон төлөвшүүлэх зорилго бүхий аймгийн аварга шалгаруулах “Өсвөрийн аврагч-2023” тэмцээний арга хэмжээг 9 дүгээр сарын 09-ний өдөр аймгийн баяр наадмын талбайд амжилттай зохион байгууллаа.

Тус тэмцээнд Архангай, Булган, Дархан-Уул, Орхон, Сэлэнгэ, Төв, Хөвсгөл аймгийн ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн 7 бүлэг оролцож аваргуудаа шалгаруулж Мандал сумын ерөнхий боловсролын 4 дүгээр сургуулийн “Сэрэмж” бүлэг амжилттай оролцож гутгаар байр эзэлсэн.

Онцгой байдлын байгууллагаас зохион байгуулсан нийслэл, дүүрэг, 21 аймгийн шилдгийн шилдгүүд цугларсан “Залуу ахлагч нарын цугларалт-2023” арга хэмжээнд 80 гаруй алба хаагч оролцож, цэргийн хэргийн мэдлэг, гадаад хэлний мэдлэг, буудлагын тэмцээн, бие бялдрын бэлтгэлжилт, багаар ажиллах чадварын тэмцээн гэсэн 5 төрлөөр мэдлэг, оюун ухаан, хурд хүчээ сорин өрсөлдсөнөөс Сэлэнгэ аймгийн Сүхбаатар сум дахь Гал түймэр унтраах, аврах 36 дугаар ангийн аврагч, гал сөнөөгч, ахлагч О.Отгон-Эрдэнэ тусгай байр эзэлж, өргөмжлөл мөнгөн шагналаар шагнагдлаа.

#### **Хоёр. Эдийн засаг, санхүүгийн бодлогын хүрээнд:**

9 сард 989 баримтаар 13,8 тэрбум төгрөгийн төсөвт байгууллагуудын төлбөр тооцоог хянан гүйцэтгэлээ.

Аймгийн 8 дугаар сарын төсвийн гүйцэтгэлийн нэгдсэн мэдээг гаргаж Статистикийн хэлтэст хугацаанд нь хүргүүлж, мөн сарын аймгийн орлогын

гүйцэтгэлийн мэдээг Татварын хэлтэстэй тулган баталгаажуулж, төсвийн гүйцэтгэлийн мэдээг сар бүр аймгийн цахим хуудас, шилэн данс болон ил тод самбарт байршуулан ажиллаж байна.

Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтын санхүүжилтийг сум бүрт хуваарилж, тусгай зориулалтын шилжүүлгийн санхүүжилт олгосон.

### 1.Төсвийн гүйцэтгэлийн талаар:

Д/д	Үзүүлэлтүүд	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Хувь
<b>1. Орон нутгийн төсвийн нийт орлого</b>		69,028,753.2	69,133,425.3	624.5
<b>1.1</b>	<b>Орон нутгийн төсвийн орлого</b>	38,336,985.0	43,112,859.4	112.5
	Үүнээс: Аймгийн төсвийн орлого	17,014,601.4	11,977,662.5	70.4
	Сумдын төсвийн орлого	21,322,383.6	31,135,196.9	146.0
<b>1.2</b>	Сумдаас авах орлогын шилжүүлэг	3,527,844.0	3,272,267.0	92.8
<b>1.3</b>	Урьд оны үлдэгдэл /Орон нутгийн орлого/	11,592,668.3	11,592,668.3	100.0
<b>1.4</b>	Урьд оны үлдэгдэл /Орон нутгийн хөгжлийн сан/	7,996,443.6	4,996,443.6	62.5
<b>1.5</b>	Хандив /Орон нутгийн хөгжлийн сан/	600,000.0	-	-
<b>1.6</b>	Төсөвт байгууллагын өөрийн орлого	1,077,409.0	1,080,477.0	100.3
<b>1.7</b>	Сум хөгжүүлэх сангийн орлого	1,881,345.1	1,062,651.8	56.5
<b>2. Орон нутгийн төсвийн нийт зарлага</b>		69,028,753.2	46,750,972.8	67.7
<b>2.1</b>	<b>Орон нутгийн төсвийн нийт зарлага</b>	69,028,753.2	46,750,972.8	67.7
	Үүнээс: Сумдын орон нутгийн байгууллагуудын зарлага	35,534,966.1	27,658,292.7	77.8
	Сумдын орон нутгийн хөгжлийн сан	11,978,177.1	6,446,159.8	53.8
	Аймгийн шууд харьцдаг байгууллагуудын зарлага	21,515,610.0	12,646,520.3	58.8
	Үүнээс: Аймгийн төсвийн хөрөнгө оруулалт	5,896,964.2	2,116,167.0	35.9
	Аймгийн орон нутгийн хөгжлийн сан	6,646,745.7	3,055,565.0	46.0
	Халамжийн сан	110,118.0	92,119.0	83.7
	Шууд харьцдаг төсвийн байгууллагуудын зарлага	8,011,782.1	6,588,645.3	82.2
	Аймгийн Засаг даргын нөөц хөрөнгө	850,000.0	794,024.0	93.4
	Улсын төсөвт төвлөрүүлэх орлого	-	-	-
<b>3. Аймгаас олгосон санхүүгийн дэмжлэг, орлогын шилжүүлэг</b>		24,371,850.8	10,538,982.0	18.0
<b>3.1</b>	Сумдад олгосон санхүүгийн дэмжлэг	5,746,928.0	1,037,257.2	18.0
<b>3.2</b>	Сумдад олгосон орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлэг	11,978,177.1	6,446,159.8	-

	Үүнээс: Хот тохижуулахын урсгал зардалд	151,999.8	25,333.3	-
	Мал эмнэлгийн үйлчилгээний зардалд	-	-	-
	Хөрөнгө оруулалтын зардалд	11,978,177.1	6,446,159.8	-
<b>3.3</b>	Аймагт олгосон орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлэг	6,646,745.7	3,055,565.0	-
	Үүнээс: Хөрөнгө оруулалтын зардалд	6,646,745.7	3,055,565.0	-
	Мал эмнэлгийн үйлчилгээний хяналтын зардалд	198,550.2	117,683.6	
	Усан хангамжийн татаас	-	-	-
	<b>4. Тусгай сангуудын зарлага</b>	1,881,345.1	1,062,651.8	56.5
<b>4.1</b>	Сумдын сум хөгжүүлэх сан	1,881,345.1	1,062,651.8	56.5

## 2.Өргөн хэрэглээний барааны үнэ:

Өргөн хэрэглээний барааны нэр төрөл		2022 – VIII	2023 – VIII	<u>2023 - VIII</u> <u>2022 - VIII</u>
<b>1.ХҮНСНИЙ БАРАА</b>				
<b>1.1</b>	Талх, гурил, будаа			
	Гурил /Алтантараи, I зэрэг, кг/	1 600	2 400	150.0
	Талх /орон нутгийн, ш/	1 500	2 100	140.0
	Нарийн боов /кг/	5 000	5 700	114.0
	Будаа /кг/	3 500	3 900	111.4
	Элсэн чихэр /кг/	3 300	4 400	133.3
	<b>МАХ МАХАН БҮТЭЭГДЭХҮҮН</b>			
	Хонины мах /кг/	9 000	11 000	122.2
	Үхрийн мах /кг/	11 000	12 600	114.5
	Адууны мах /кг/	8 000	10 200	127.5
	Ямааны мах /кг/	8 000	9 000	118.8
	Дотор мах, цувдай /цусгүй/	5 000	8 000	160.0
	Хиам /чанасан, кг/	16 500	15 700	95.2
	<b>1.2</b>	<b>СҮҮ, СҮҮН БҮТЭЭГДЭХҮҮН, ӨНДӨГ</b>		
	Сүү /задгай, л/	1 200	2 300	191.7
	Сүү / савласан, л/	4 500	4 700	104.4
	Тараг /задгай, л/	1 800	2 800	155.6
	Хорхой ааруул /задгай, чихэртэй, кг/	25 000	22 900	91.6
	Айраг /л/			
	Хуурай сүү /кг, Орос, 25хувь тослогтой/	6 600	8 000	121.2
	Өндөг /ш/	400	370	92.5
	Бүх төрлийн өөх тос			

	Ургамлын тос /л/	11 000	10 900	99.1
	Өөхөн тос /кг/	3 000	3 700	123.3
	Шар тос /кг/	25 000	28 900	115.6
	Масло /задгай, кг/	7 500	9 700	129.3
	<b>ХҮНСНИЙ НОГОО</b>			
	Төмс /кг/	2 000	2 000	100.0
	Лууван /кг/	2 500	2 400	96.0
	Манжин /кг/	2 500	3 800	152.0
	Байцаа /кг/	2 000	2 900	145.0
	Сонгино /кг/	2 500	2 900	116.0
	Өргөст хэмх /шилтэй, дарсан/	7 600	7 900	103.9
	Алаг салат /шилтэй, Urbanek, 630гр/	5 500	5 800	105.5
	<b>2. ШАТАХУУН</b>			
<b>2.1</b>	Бензин А - 80	2 480	2 480	100.0
	Бензин А - 92	2 500	2 500	100.0
	Дизелийн түлш	3 730	3 550	95.2

### **Гурав. Хууль, эрх зүйн бодлогын хүрээнд:**

Авлигатай тэмцэх газартай хамтран төрийн албанд шинээр томилогдсон 20 агентлагийн 54 албан хаагчдад “Ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх нь” сэдвээр сургалт зохион байгууллаа.

Гаалийн ерөнхий газрын харьяа Сэлэнгэ аймаг дахь Гаалийн газарт гаалийн зөрчлийн улмаас хураагдсан 189,6 кг, 424,704 төгрөгийн үнэ бүхий гахайн мах, Байгаль орчин аялал жуулчлалын газрын байгаль орчны улсын байцаагчийн хураан авсан 1 ширхэг хийлдэг завь, 2 ширхэг сэлүүр, загасны торыг устгах ажлыг Эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр хураан авсан хөрөнгө, эд зүйл, хэрэгслийг үнэлэх, худалдан борлуулах, устгах талаар шийдвэр гаргах, хэрэгжилтэд хяналт тавих орон тооны бус зөвлөлийн шийдвэрийн дагуу 9 дүгээр сарын 20–ны өдөр зохион байгуулсан.

**Цагдаагийн газар:** 9 дүгээр сарын байдлаар нийт 530 гэмт хэрэг бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 94 (15.1 хувь)-аар буурсан байна. Нийт 45857 зөрчил бүртгэгдсэн нь өмнөх оны мөн үеэс 24458 (75.2 хувь)-аар өссөн байна.

**Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар:** Тайлант сард иргэний шийдвэр гүйцэтгэх тасагт 90 гүйцэтгэх хуудасны 1,905,810,000 төгрөгийн шийдвэр шинээр ирж, 61 гүйцэтгэлийн хуудасны 167,010,800 төгрөгийн шийдвэрийг гүйцэтгэж хаасан. Хорихоос өөр төрлийн ял, албадлагын арга хэмжээгээр шийтгэгдсэн 13 гүйцэтгэх хуудас ирж, 26 гүйцэтгэх хуудас хаасан.

**Шүүх шинжилгээний хэлтэс:** Тайлант сард шүүх эмнэлгийн шинжилгээний тоо 58, хүний биед гэмтлийн зэрэг тогтоох шинжилгээний тоо 47, хэргийн газрын үзлэгээр илрүүлж бэхжүүлсэн ул мөр эд мөрийн баримтын тоо 51, гэрэл зургийн ажлын тоо 1293, криминалистикийн шинжилгээ 3, цогцост хийсэн шинжилгээ 11 байна.

**Улсын бүртгэлийн хэлтэс:** 9 дүгээр сарын иргэний бүртгэлийн талаарх мэдээлэл.

- Төрсний бүртгэл - 146 /эрэгтэй-78, эмэгтэй-68/
- Гэрлэлтийн бүртгэл - 35
- Гэрлэлт цуцалсны бүртгэл - 14

- Үрчлэлт - 4
- Эцэг, эх тогтоолт – 14 /үүнээс эрэгтэй 10, эмэгтэй 4/
- Овог эцэг /эх/-ийн нэр, нэр өөрчилсний бүртгэл - 9
- Нас баралт - 58
- Нийт олгосон иргэний үнэмлэх - 369
- Шинээр олгосон иргэний үнэмлэх - 158
- Дахин олгосон иргэний үнэмлэх - 47
- Иргэний үнэмлэхийн хугацаа дуусаж авсан - 164
- Гадаад паспорт олголт - 307
- Аймаг хотоос бүр мөсөн шилжин ирсэн – 221 /үүнээс насанд хүрсэн 117, хүүхэд 104/
- Хот доторх шилжилт хөдөлгөөн - 232 тус тус бүртгэгдсэн байна.

Газар өмчлөх, эзэмших, ашиглах эрхийн улсын бүртгэлийн талаар:

- Хүлээн авсан мэдүүлгийн тоо - 528
- Анхны бүртгэл - 148
- Өмчлөх эрх шилжих гэрээ - 137
- Барьцааны гэрээ - 210
- Бүртгэлд өөрчлөлт оруулах - 23
- Лавлагаа хуулбар - 6
- Нийт бичигдсэн гэрчилгээний тоо – 304

Газраас бусад үл хөдлөх эд хөрөнгө, өмчлөх эрхийн улсын бүртгэлийн талаар

- Хүлээн авсан мэдүүлгийн тоо- 574
- Анхны бүртгэл- 33
- Өмчлөх эрх шилжих гэрээ-104
- Барьцааны гэрээ- 404
- Бүртгэлд өөрчлөлт оруулах- 15
- Лавлагаа хуулбар-2
- Нийт бичигдсэн гэрчилгээ-152

### **Дөрөв. Нийгмийн бодлогын хүрээнд:**

#### **Боловсролын чиглэлээр:**

Боловсролын Ерөнхий газрын 2023-2024 оны хичээлийн жилд зохион байгуулах ажил мэргэжлийн чиг баримжаа олгох үйл ажиллагааны зөвлөмж чиглэлийг 35 сургууль, 3 мэргэжлийн боловсролын байгууллагуу ,жлргүүхү мэргэжилтний судалгааг цахимаар хүргүүлэв.

ЕБС-ийн 3-4 дүгээр ангид Математикийн хичээлийн долоо хоногийн 1 цагийг “Эдүтэн” цахим систем ашиглан зохион байгуулахаар бэлтгэн дэмжих баг бүрдүүлж, сургагч багшаар бэлтгэх сургалтыг 8 дугаар сарын 20-22-ны өдрүүдэд зохион байгуулж 108 багш хамрагдсан. Тус платформыг ашиглах 3,4 дүгээр ангийн багш, сурагчдын мэдээллийг нэгтгэн 155 бүлгийн 4386 сурагч ашиглахаар бэлтгэл ажил хийгдэж байна.

Хичээлийн жилд 12-р ангийн сонгон судлах хичээлийг сонгосон сурагчдын тоог судлагдахуун бүрээр авлаа. Одоогийн байдлаар судалгаагаар 34 сургуулийн 72 бүлэгт 12-р ангид 1050 сурагч суралцаж байгаа бөгөөд математикийг 34 сургуулийн 855, англи хэлийг 32 сургуулийн 730, нийгэм судлалыг 27 сургуулийн 555 сурагч, бизнес судлал, мэдээллийн технологийн хичээлийг тус бүр 1 сурагч сонгосон бол уран зохиол, дизайн зураг зүй, техник технологийг хүүхэд сонгоогүй байна.

Хүүхдийн шинжлэх ухаанч байдлыг дэмжих, оюуны болон биет бүтээлүүдийг шалгаруулж, урамшуулах, шилдэг бүтээлүүдийг сурталчлах зорилготой “Science fair-шинжлэх ухааны бүтээлийн уралдаан” зохион байгуулах бэлтгэл ажлыг зохион байгуулж, сургуулийн захирал, сургалтын менежер, хими, биологи, физикийн багш болон уралдаанд оролцох сурагчдад тус уралдааны талаар “Гэртээ туршъя” ТББ-тай хамтран мэдээлэл өгч идэвхжүүлээ.

#### **Эрүүл мэндийн чиглэлээр:**

Аймгийн хэмжээнд 0-17 насны хүүхдийн 2 багц үзлэг, оношилгоонд 37981 хүүхэд хамруулахаас 22878 хүүхэд хамрагдаж гүйцэтгэл 60.2 хувь, насанд хүрэгчдийн 4 багц оношилгоонд 69918 иргэн хамруулахаас 6828 насанд хүрсэн иргэн хамруулж гүйцэтгэл 9.8 хувьтай байна.

Орчны эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын чиглэлээр 15 объектын судалгааг эрсдэлийн ангиллын жагсаалтаар Эрүүл мэндийн яамны Салбарын хяналтын газарт цахимаар хүргүүлж, Хяналтын газрын даргын баталсан удирдамжийн хүрээнд орчны эрүүл ахуй, халдвар хамгааллын хяналтын чиглэлээр 15 объектод хийж гүйцэтгэн 12 албан шаардлагыг 227 заалттайгаар хүргүүлж биелэлтийг тооцож ажиллахаар шийдвэрлэсэн. Өмнөх оны эрсдэлийн хувьтай харьцуулахад эрсдэл үүсэх магадлал 74.1 хувь буюу 9.35 хувиар өссөн, хууль сахин мөрдөлт 25.9 хувь буюу 9.35 хувиар буурсан үзүүлэлттэй гарсан.

“Ахуйн болон урьдчилан цэвэрлэх байгууламжийн үйл ажиллагаа, цэвэрлэсэн бохир усанд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх тухай” удирдамжийн хүрээнд 4 аж ахуйн нэгжийн цэвэрлэх байгууламж руу орж буй бохир уснаас 4 дээж, цэвэрлэсэн бохир уснаас 4 дээж нийт 8 дээж, Мандал, Сүхбаатар сумын мах төхөөрөх цехээс 4 дээж авч аймгийн Стандарт хэмжил зүйн хэлтсийн эрүүл ахуйн хөрс, усны хяналтын итгэмжлэгдсэн лабораторид химийн үзүүлэлт тодорхойлуулахаар шинжилгээнд хамруулсан. Цэвэрлэх байгууламжуудын цэвэрлэгээний түвшин дунджаар 67.3 хувьтай байна.

#### **Хөдөлмөр, халамжийн чиглэлээр:**

Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, тусламж хөнгөлөлтийн үйлчилгээг зорилтот бүлэгт түргэн шуурхай, хүнд сурталгүй чанартай хүргэх ажлын хүрээнд:

- Нийгмийн халамжийн тэтгэвэрт 2327 иргэнд 5,893,297,332 төгрөг
- Нийгмийн халамжийн тэтгэмжид 1852 иргэнд 2,361,243,850 төгрөг
- Амьжиргааг дэмжих нөхцөлт мөнгөн тэтгэмжид 1651 иргэнд 1,150,347,671 төгрөг
- Жирэмсэн эхийн тэтгэмжид 727 эхэд 220,156,060 төгрөг
- 0-3 хүртэлх насны хүүхэд асарсны тэтгэмж 4218 эхэд 1,744,497,769 төгрөг
- Ихэр хүүхдийн тэтгэмжид 11 иргэнд 22,000,000 төгрөг
- Өрх толгойлсон эхийн тэтгэмжид 225 иргэнд 368,465,696 төгрөг
- Ахмад настанд олгох хөнгөлөлт, тусламжинд 3554 ахмадын 388,400,334 төгрөг
- Хөгжлийн бэрхшээлтэй иргэнд үзүүлэх хөнгөлөлт, тусламжинд 334 иргэний 104,149,499 төгрөг
- Алдар цолтон ахмад настанд олгох хөнгөлөлт, тусламжид 48 иргэнд 8028050 төгрөг
- Насны хишиг тэтгэмжид 5800 иргэнд 892,680,000 төгрөг
- Эхийн алдар одонгийн тэтгэмжид 9420 иргэнд 1,251,500,000 төгрөг
- Хүнсний эрхийн бичгийн 1790 иргэнд 174,504,000 төгрөг
- Хүүхдийн мөнгөн тэтгэмжид 38200 иргэнд 34,380,000,000 төгрөг
- Орон гэрийн хөнгөлөлт, тусламжид 32 иргэнд 38,400,000 төгрөг
- Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээнд 103 иргэнд 50,900,000 төгрөг



- Амьжиргааг дэмжих зөвлөлийн гишүүдийн урамшуулалд 175 иргэнд 60,72,000 төгрөгийг тус тус зарцууллаа.

#### **Хөдөлмөр эрхлэлтээр:**

Хөдөлмөр эрхлэлтийн нийтлэг үйлчилгээг хүртээмжтэй, чанартай хүргэхээр дараах үйлчилгээг иргэдэд үзүүллээ. Үүнд:

- Ажил олгогчийн мэдээлэл - 25
- Ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, зөвлөгөө өгөх, мэдээллээр хангах үйлчилгээнд 568 иргэн
- Идэвхтэй ажил хайгчаар – 221 иргэн
- Ажил зуучлах үйлчилгээнд – 147 иргэн
- Сул чөлөөтэй 185 ажлын байр
- Шинээр бий болсон 46 ажлын байрыг бүртгэж мэдээллэсэн байна.

Сумдын Хөдөлмөр эрхлэлт, халамжийн асуудал хариуцсан мэргэжилтэн, хувиараа болон албан бус хөдөлмөр эрхлэгч иргэн, малчид, жижиг дунд үйлдвэр, хоршоо, нөхөрлөлийн 30 төлөөллийг хамруулан ХАБЭА-н ахисан түвшний сургалтыг “Алтан боломж” сургалтын төвтэй хамтран зохион байгуулсан.

Залуучуудын хөдөлмөр эрхлэлтийг дэмжих чиглэлээр санхүүжүүлж буй “СТАРТ-АП” арга хэмжээг “Бэст метод” ХХК-тай хамтран 9 дүгээр сарын 8-10-ны өдрүүдэд залуучуудын бүтээлч санаа, санаачлага, гарааны бизнесийн хөгжүүлэлтийг дэмжин ажиллах чиглэлээр 3 хоногийн сургалт зохион байгууллаа. Сургалтад 4 сумын 7 бүлгийн 20 залуучууд хамрагдсанаас 4 бүлэг шалгарч бэлтгэл хурдасгуурт хамрагдаж байна.

#### **Гэр бүл, хүүхэд залуучуудын чиглэлээр:**

Хүүхдийн тусламжийн 108 утсаар 9 дүгээр сард 191 дуудлага ирснээс 120 кейст ажиллагаа хийгдсэн байна.

Хүүхдийн эрхийн улсын байцаагчийн чиг үүргийн хүрээнд хүүхдийн эрх зөрчигдсөн өргөдөл гомдол 3, хүүхдийн мөнгөн тэтгэмжтэй холбоотой 1 өргөдөл гомдлыг шийдвэрлэлээ.

Сүхбаатар, Цагааннуур сумдын бэлгийн хүчирхийллийн хохирогч 2 хүүхдийн хууль ёсны төлөөлөгчөөр ажиллаж, 1 хохирогч хүүхдийн шүүх хуралд өмгөөлөгчийн хамт оролцсон бөгөөд эргэх холбоотойгоор зөвлөн туслах үйлчилгээ үзүүлж байна.

Орхон сумын бүсийн уралдаанд мориноос унаж хүнд бэртсэн хүүхдэд гэр бүлийн нөхцөл байдлын үнэлгээ, эргэн хяналтыг хийж, эргэх холбоотой ажиллаж, холбогдох асуудлыг хүүхэд хамгааллын багаар хэлэлцэж дэмжлэг тусалцаа үзүүллээ.

Мандал сумын хүүхдийн ордонд 5 төрлийн дугуйланд 52 хүүхэд, Орхонтуул Хүүхэд хөгжлийн төвд 6 төрлийн дугуйланд 51, аймгийн Гэр бүл хүүхэд залуучуудын газрын дэргэдэх 2 төрлийн дугуйланд 18 нийт 121 хүүхэд хамрагдаж байна.

Хүүхдийн оролцооны үндэсний чуулганыг Монгол Улсын Ерөнхий сайд Л.Оюун-Эрдэнийн санаачилгаар Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газар, Олон улсын хүүхдийн Найрамдал цогцолбор, Хүүхдийн оролцооны үндэсний сүлжээтэй хамтран Төрийн ордонд зохион байгуулж аймгийн Хүүхдийн зөвлөлөөс 9 хүүхэд, 1 чиглүүлэгч багшийн бүрэлдэхүүнтэй оролцож дуу хоолойгоо өргөлөө. Чуулганы гол үйл явц болох үндэсний хэлэлцүүлэгийг “Хүүхдийн эрхийг дээдэлье” уриан дор хэлэлцэж Монголын Үндэсний хүүхдийн зөвлөлийн дэд зөвлөлийн бүрэлдэхүүнд Сэлэнгэ аймгийн Хүүхдийн зөвлөлийн тэргүүн Байгалмаагийн Түмэн-Өлзий сонгогдлоо.

Мөн чуулганд оролцогч 21 аймаг, 9 дүүргийн дунд зохион байгуулсан бичил төслийн уралдаанд Сэлэнгэ аймгаас оролцогчид “X PROJECT” баг “Гэгээ” төслөөр хэлэлцэн 3 дугаар байранд шалгарав.

Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх хоёр сарын нөлөөллийн аяны хүрээнд дараах ажил арга хэмжээг зохион байгууллаа. Үүнд:

Цагдаагийн газар, Онцгой байдлын газар, Сүхбаатар сумын 2 дугаар цэцэрлэг зэрэг байгууллагуудыг уриалан Гэр бүлийн хүчирхийллээс урьдчилан сэргийлэх видео шторк, 3 төрлийн постер бэлтгэн цахим хуудсаар олон нийтэд түгээлээ. Хандалт, шэйр тус үйл ажиллагаа нь гэр бүлийн хамтач уур амьсгалыг бий болгох, нэгнээ хайрлах, хүндлэх зэрэг эерэг мессежийг олон нийтэд түгээн сурталчиллаа.

Цагааннуур сумын Ерөнхий боловсролын сургуулийн 9-12 дугаар ангийн 185 сурагчдад “Хүүхдийн харилцаа, хандлага” сэдвээр 4 удаагийн давталттай сургалт зохион байгуулсан.

Түр хамгаалах байраар 9 дүгээр сард гэр бүлийн хүчирхийлэлд өртсөн 4 /Бие махбодийн хүчирхийлэлд өртсөн 2, сэтгэл санааны хүчирхийлэлд өртсөн 1, үл хайхрах хүчирхийлэлд өртсөн 1/ хохирогчдод нийт 12 хоног хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлсэн. 5 хүүхдэд сэтгэл зүйн ганцаарчилсан зөвлөгөө үйлчилгээ үзүүлж, сэтгэл зүйн тест авсан. Мөн түр хамгаалах байраар үйлчилгээ авсан 1 хүүхдэд үе шаттайгаар сэтгэл зүйн зөвлөгөө үйлчилгээг үзүүлсэн.

Шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд “Next Gen 2022” төслийн уралдаанд шалгарсан “Энэрэлт Үйлс” НҮТББ-тай хамтран ажиллах гэрээ байгуулж үндсэн санхүүжилтын 70 хувь болох 14,000,000 төгрөгийн санхүүжилтыг шийдвэрлэж дэмжин ажилласан.

Залуучуудын хөгжлийн есдүгээр чуулган зохион байгуулагдахтай холбогдуулан Сүхбаатар, Орхонтуул сумын Рашаант тосгоны залуучуудын дунд “Дэд хэлэлцүүлэг” зохион байгуулж, гаргасан санал санаачилгыг Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг Гэр бүл, хүүхэд, залуучуудын хөгжлийн газарт хүргүүлсэн.

#### **Биеийн тамир спортын чиглэлээр:**

“Мобиком” ХХК-ийн Сэлэнгэ аймаг дахь салбарын 25 жилийн ойд зориулан зохион байгуулагдсан Сагсан бөмбөгийн тэмцээн 9 дүгээр сарын 23,24-ний өдрүүдэд зохион байгуулагдаж, тэмцээнд эрэгтэй 20, эмэгтэй 8 нийт 28 баг тамирчид оролцлоо.

Уулын дугуйн Улсын аварга шалгаруулах тэмцээн 9 дүгээр сарын 23,24-ний өдрүүдэд зохион байгуулагдаж, Улаанбаатар хот, Сэлэнгэ, Дархан, Орхон, Дорноговь, Өмнөговь, Ховд аймгуудын 27 байгууллагын 150 дугуйчин 99 медалийн төлөө кросс каунтри, марафон 16 насны ангилалд уралдлаа. Тэмцээний 2 өдрийн багийн дүнгээр Сэлэнгэ аймгийн “Мөнгөн хэгээс” дугуйн холбоо тэргүүлж, Дугуйтай Сэлэнгэ клуб дэд байр, Улаанбаатар хотын “Манай найзууд” клуб гуравдугаар байранд шалгарлаа.

Биеийн тамир спортын тухай хууль, “Алсын хараа- 2050” урт хугацааны хөгулийн бодлого, засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Эрүүл монгол хүн үндэсний хөдөлгөөн, Эерэг хандлага эрүүл нийгэм арга хэмжээг орон нутагт хэрэгжүүлэх биеийн тамирын арга зүйчдийн мэдлэг, мэргэшлийг дээшлүүлэх чадавхжуулах сургалт 9 дүгээр сарын 20,21-ний өдрүүдэд Улаанбаатар хотноо зохион байгуулагдаж аймгийн төлөөлөл 13 хүн оролцлоо. Мөн 21 аймаг 9 дүүргийн арга зүйч нарын дунд ББТТСорил авах аргачилал түүнд хийх анализ сэдвээр уралдаан зохион байгуулагдаж манай аймгаас 6 арга зүйч оролцож багийн дүнгээр 2-р байр эзэлсэн амжилт үзүүллээ.

#### **Тав. Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлогын хүрээнд:**

**Хүнс, хөдөө аж ахуйн чиглэлээр:** Ургац тогтоолтын дүнгээр 131.8 мянган га талбайгаас 14.7 цн буюу 193 мянган тн үр тариа, үүнээс улаанбуудай 126

мянган га талбайгаас 15.6 цн буюу 197 мянган тн, бусад үр тариа 5.3 мянган га талбайгаас 12 цн буюу 6.3 мянган тн, тэжээлийн ургамал 17.3 мянган га талбайгаас 12 цн буюу 21.2 мянган тн, тосны ургамал 51.3 мянган га талбайгаас 5.7 цн буюу 29.2 мянган тн, төмс 2.3 мянган га талбайгаас 124.5 цн буюу 29.5 мянган тн, хүнсний ногоо 4 мянган га талбайгаас 132 цн буюу 53.6 мянган тн ургац хураан авах урьдчилсан баланс гарсан.

Улаанбуудай сортын хянан баталгаа хийлгэхээр хүсэлт ирүүлсэн 13 сумын 32 аж ахуй нэгжийн 59 нэгж талбарт улаанбуудайн сортын хянан баталгаа хийхэд 14693.3 га талбай тэнцсэн, 10 нэгж талбарын 4014 га талбай тэнцээгүй.

Үр тариа 6299 га талбайгаас 15.5 цн буюу 9755 тн, үүнээс улаанбуудай ангилан хадсан 13270 га талбай цайруулсан болон шууд хураалт 6199 га талбайгаас 15.6 цн буюу 9673 тн, бусад үр тариа 100 га талбайгаас 82 тн, тэжээлийн ургамал 230 га талбайгаас 434тн, тосны ургамал 1851 га талбайгаас 916тн, төмс 952.1 га талбайгаас 11259 тн, хүнсний ногоо 1279.2 га талбайгаас 16525.8 тн тус тус хураан авч, ургац хураалтад 426 комбайн, 127 будаа цэвэрлэгч, 133 будаа ачигч, 26 төмсний комбайн, 8 даршны комбайн, 28 төмс ухагч, 23 механикжсан үртрэм, 70 үр сортлогч, 148 хадагч жатка ажиллахад техник засвар үйлчилгээний ажил хийгдэж, техникийн бэлэн байдал 90 хувьтай, ургац хураалтад 9 сумын 65 аж ахуйн нэгжид 993 хүн ажиллуулах захиалга өгөөд байна.

Аймгийн хэмжээнд 1170 тн өвс, 710 тн тэжээлийг аюулгүйн нөөцөд бэлтгэж малчдын түвшинд 160.9 мянган тн байгалийн өвс, 46.5 мянган тн үйлдвэрийн тэжээл, 5.8 тн давс, хужир, шүү бэлтгэхээс 61.8 мянган тн байгалийн хадлан, 15 тн дарш, 41 тн эрдэст тэжээл бэлтгэж, малчдын түвшинд хадлангийн бэлтгэлийн ажлын явц 38,4 хувьтай байна.

Аймгийн баялаг бүтээгчдийн үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүнийг сурталчлах, брэнд бүтээгдэхүүний үйлдвэрлэл, дотоодын худалдан авалтыг нэмэгдүүлж, зах зээлийг өргөтгөн борлуулалтад дэмжлэг үзүүлэх зорилгоор аймгийн төв Сүхбаатар хотод “Сэлэнгэ Алтан намар-2023” үзэсгэлэн худалдааг зохион байгуулж, 16 сум, 6 тосгоноос 126 аж ахуйн нэгж, иргэдийн 100 гаруй нэр төрлийн төмс, хүнсний ногоо, жимс жимсгэнэ, сүү цагаан идээ, зөгийн бал, даршилж савласан ногоо, тос, эмийн ургамал, гар урлал, модны сулгац, ноос ноолууран эдлэл, арьс, ширэн эдлэл, саван, гутал, зэрэг бүтээгдэхүүнтэйгээр оролцож 64,6 сая төгрөгийн борлуулалтыг хийсэн.

**Мал эмнэлгийн чиглэлээр:** Аймгийн хэмжээнд гахайн сонгомол мялзан өвчний дархлаажуулалтад 443.2 мянган толгой мал, амьтан хамрагдахаас 398.8 мянган толгой амьтан хамрагдаж 89.9 хувьтай, урьдчилан сэргийлэх тарилгад давхардсан тоогоор 219.0 мянган толгой мал, амьтан хамрагдахаас 204.7 мянган толгой мал, амьтан хамрагдаж 93.4 хувьтай, аж ахуйн нэгж, байгууллага, иргээдээс төлбөр авах тарилгад 470000 толгой мал хамрагдахаас 468.5 мянган толгой мал, амьтан 99.6 хувьтай давхардсан тоогоор 1.1 сая толгой мал, амьтан хамрагдахаас технологит хугацаанд 1.0 сая толгой мал, амьтан хамрагдаж 94.7 хувийн гүйцэтгэлтэй технологит хугацаанд үргэлжлэн явагдаж байна.

Мал Эмнэлгийн Ерөнхий газрын даргын 2023 оны “Төлөвлөгөө удирдамж батлах тухай” А/33 дугаар тушаал, аймгийн Засаг даргын “Мал эмнэлгийн нэгдсэн арга хэмжээ зохион байгуулах тухай” А/165 дугаар захирамжийн хүрээнд шимэгчтэх өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд давхардсан тоогоор 6.1 сая толгой мал, амьтан хамрагдахаас угаалгад 1.4 сая толгой мал, туулгалтад 1.4 сая толгой мал, боловсруулалтад 1.2 сая толгой мал, амьтан, нохой, муурын үржил хязгаарлах ажилбарт 301 толгой нохой, муур тус тус хамруулж, давхардсан тоогоор нийт 4.1 сая толгой мал, амьтан буюу 68.4 хувийн гүйцэтгэлтэй технологит хугацаанд үргэлжлэн хийгдэж байна.

Мал эмнэлгийн нийт 172 цахим гэрчилгээгээр 2899 толгой мал, амьтан шилжилт хөдөлгөөн хийснээс өөр аймаг суманд мал эмнэлгийн 83 цахим гэрчилгээгээр 1309 толгой мал амьтан /отор-635, үржил-674/ явсан, өөр аймаг сумаас мал эмнэлгийн 65 цахим гэрчилгээгээр нийт 937 толгой мал, амьтан /отор-540, үржил-447/ ирсэн, аймаг дотроо мал эмнэлгийн цахим 24 гэрчилгээгээр нийт 653 толгой мал, амьтан /отор-480, үржил-173/ шилжилт хөдөлгөөн хийж, хяналт тавьсан.

Сүхбаатар сумын хэмжээнд хүнсний зах дэлгүүрт худалдан борлуулж буй мах махан бүтээгдэхүүний 3967 кг үхрийн махны 36 дээж, 95 кг адууны махны 1 дээж, 1056 кг хонины махны 58 дээж, 265 кг ямааны махны 21 дээжид ариун цэврийн магадлан шинжилгээг стандарт арга зүйн дагуу хийсэн.

Ариун цэвэр нян судлалын шинжилгээг 31 аж ахуй нэгжийн импортоор орж ирсэн гахайн мах 384,1 тн, тахайны мах 64.2 тн, өндөг 302.4 мянган ширхэг, үхрийн хагас боловсруулсан бүтээгдэхүүн 4.8 тн буюу нийт 448.3 тн махны 92 сорьц дээжинд тус тус эмийн бодисын үлдэгдэл, уургийн задрал болон бусад магадлан шинжилгээг олон улсын стандарт арга зүйн дагуу тус тус шинжилж баталгаажуулж, холбогдох газарт шилжүүлж, Түшиг, Баруунбүрэн, Жавхлант, Сант сумын 87 дээжид шимэгч судлалын шинжилгээ хийсэн.

**Байгаль орчин, аялал жуулчлалын чиглэлээр:** 2023 оны Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар хийгдсэн Алтанбулаг, Сайхан, Орхон, Орхонтуул сумдад 5 га талбайд ойн зурвас байгуулах ажлыг “Тэнгэрлэг Ой” ХХК, “Ойн хүрэм” ХХК, Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаар “Аймгийн хэмжээнд агнуур зохион байгуулалтыг мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэх” ажлыг “Монголын анчдын нийгэмлэг” ТББ хийж гүйцэтгэн хүлээн авлаа.

“Нөхөн сэргээлт-2024” арга хэмжээний хүрээнд “Оюу толгой” ХХК-ийн захиалгаар “Ялбагт Бугант нандин” ХХК, “Үзэгт дэлгэрэх” ХХК-иуд нь нийт 397 га талбайд нөхөн сэргээлт хийж, Байгаль орчин аялал жуулчлалын яамны ажлын хэсгийн хамтаар газар дээр нь үзэж танилцан 2 аж ахуйн нэгжид зарим хэсгүүдийг дахиж засаж хэлбэржүүлэх зэрэг арга хэмжээ авах талаар үүрэг өглөө.

Хилийн боомтын үйлчилгээг сайжруулах төслийн хүрээнд “Эйч кэ би” ХХК нь Алтанбулаг хилийн боомтын 1,7 км замыг ашиглалтад хүлээлгэн өгөхтэй холбоотой карьер ашиглалт, цаашдын нөхөн сэргээлт хийх үүрэг чиглэл өгч ажиллалаа.

01/06 дугаартай “Амралтын газар, жуулчны бааз, гэр кемп, ШТС-дын ариун цэврийн байгууламж стандартын шаардлага хангаж буй эсэхэд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх тухай” удирдамжийн дагуу аж ахуйн нэгж, байгууллагад 44 заалт бүхий албан шаардлага өгч, 1 иргэн, 2 аж ахуйн нэгж, байгууллагад зөрчлийн хэрэг нээн зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулж байна.

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээгүй, газрын зориулалтыг өөрчилж, усан сан бүхий газар онцгой хамгаалалтын бүсэд амралтын газрын зориулалтаар барилга байгууламж барьсан 3 аж ахуйн нэгж, газар эзэмших гэрээ, гэрчилгээгүйгээр амралт аялал жуулчлалын барилга байгууламж барьж үйл ажиллагаа явуулж буй 5 иргэн, аж ахуйн нэгжийг харьяаллын дагуу шилжүүлэхээр ажиллаж байна.

Ойн тухай хууль, тогтоомж зөрчсөн, зохих зөвшөөрөлгүй мод модон материал тээвэрлэсэн 1 зөрчилд Зөрчлийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.9.11 дэх заалтын дагуу зөрчлийн хэрэг нээн зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулж хяналт шалгалтын ажил үргэлжилж байна.

Байгалийн ургамлын тухай хууль зөрчиж хууль бусаар бэлтгэсэн 25 шуудай ганга өвс, Газрын хэвлийн тухай хууль тогтоомж зөрчиж хураагдсан алт, дагалт

баялгийн журам зөрчиж хураагдсан 230 кг самар зэргийг “Эрх бүхий албан тушаалтны шийдвэрээр хураан авсан хөрөнгө, эд зүйл, хэрэгслийг үнэлэх, худалдан борлуулах, устгах талаар шийдвэр гаргах, хэрэгжилтэд хяналт тавих орон тооны бус зөвлөл”-д шилжүүлж шийдвэрлэсэн.

**Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын чиглэлээр:** Сэлэнгэ аймаг, “Хөдөө аж ахуйн менежмент экосистемийн тогтвортой байдлыг хангах” (STREAM) төсөлтэй хамтран аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг газрын мэргэжлийн байгууллага болох “Вектор мэл”ХХК-аар гүйцэтгүүлж байгаа.

Тус ажлын хүрээнд аймгийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөөг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөг 5 жилийн давтамжтайгаар 3 үе шатанд хувааж 2024-2028 он хүртэлх хугацаанд төлөвлөснөө танилцуулж сумдын Засаг дарга, газрын албаны мэргэжилтнүүдийг оролцуулсан ээлжит хэлэлцүүлэг болж, оролцогчдын саналыг авах уулзалтыг зохион байгууллаа.

Газар эзэмших эрхийн гэрчилгээний хугацаа сунгах, нэгж талбар нэгтгэх тухай 2 иргэний хүсэлт, газар эзэмших эрхийн гэрчилгээг бусдад шилжүүлэх тухай хүсэлт гаргасан 13 иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хүсэлтийн дагуу аймгийн Засаг даргын захирамжаар газрын эзэмших эрхийг шилжүүлж, газар эзэмших эрхийг хэсэгчлэн шилжүүлэх хүсэлт гаргасан 2 иргэний хүсэлтийг шийдвэрлэлээ.

Эд хөрөнгийн эрхийн улсын бүртгэлийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн 28.1-д зааснаар 1 иргэн, аж ахуйн нэгж байгууллагын газар эзэмших эрхийн гэрчилгээнд Э дугаар авах хүсэлтийг дундын мэдээллийн сангаар дамжуулан Улсын бүртгэлийн хэлтэст илгээж, газар эзэмших эрхийн гэрээ, гэрчилгээг шинэчилсэн.

Аймгийн Алтанбулаг сумын нутаг дэвсгэрт түгээмэл тархацтай ашигт малтмалын хайгуулын тусгай зөвшөөрөл хүссэн “Сэлэнгэ есөн эрдэнэ” ХХК-ийн газрын байршлыг ой, ус, усан сан бүхий газрын хамгаалалтын бүс, суурьшлын бүс болон ногоон бүсээс 1 км-ээс хол байгаа эсэх, газрын кадастрын мэдээллийн сангаас бусдын өмчлөл, эзэмшил, ашиглалтад олгогдсон газар болон орон нутгийн тусгай хамгаалалттай газартай давхцалтай эсэхийг шүүж хариуг холбогдох газарт хүргүүлэн ажиллалаа.

Газар өмчилж, эзэмшиж байгаа иргэн, аж ахуйн нэгж байгууллагын мэргэжлийн байгууллагаар хэмжилт, боловсруулалт хийлгэсэн 17 нэгж талбарын кадастрын зургийг хүлээн авч аймгийн газрын кадастрын мэдээллийн нэгдсэн сан, Лэнд менежер програмд бүртгэж баталгаажуулсан.

Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын салбарын улсын ерөнхий байцаагчийн баталсан 02-00/12 дугаартай төлөвлөгөөт хяналт шалгалт хийх удирдамжийн дагуу Мандал, Баруунбүрэн, Хүдэр суманд хяналт шалгалтыг хийж, хугацаатай албан шаардлага өгч биелэлтийг тооцон ажиллаж байна.

Сүхбаатар сумын хэмжээнд Газрын тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавьж, илэрсэн зөрчилд Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаа явуулж нийт 5 иргэний зөрчлийг хялбаршуулсан журмаар шийдвэрлэж торгууль оногдуулж барагдуулсан ажилласан.

### **Зургаа. Сум орон нутгийн ажил үйлчилгээний талаар:**

#### **Алтанбулаг сум:**

Нэгдсэн Үндэсний байгууллагын Хүүхдийн сангийн санхүүжилтээр сумын Эрүүл мэндийн төв эмнэлгийн тусламж үйлчилгээнд нэн шаардлагатай УАЗ фургон маркийн автомашинтай боллоо.

Алтанбулаг сумын хилийн боомтоор дамжин өнгөрөх зорчигч болон тээврийн хэрэгслийн нэвтрэх чадварыг сайжруулах, гадаад худалдааны эргэлтийг нэмэгдүүлэх, Алтанбулаг сумын төвийн замын хөдөлгөөний ачааллыг бууруулах, нутгийн иргэдийн аюулгүй эрүүл орчинд амьдрах нөхцлийг бүрдүүлэх зорилгоор Азийн хөгжлийн банкны 14.8 тэрбум төгрөгийн хөнгөлттэй зээлээр санхүүжигдсэн 4

эгнээ 1.7 км урттай хатуу хучилттай хөрсний ус зайлуулах дренаж систем бүхий засмал зам, 7000 м2 талбай бүхий авто зогсоолын зам талбайн ажлыг “Эйч Кэ Би Интернэйшнл Холдинг” ХХК 2019-2023 оны хооронд хийж гүйцэтгэсэнийг Монгол улсын Зам тээврийн хөгжлийн яам болон холбогдох салбар чиглэлийн мэргэжлийн байгууллагын багаас бүрдсэн ажлын хэсэг 9 дүгээр сарын 13-ны өдөр улсын комисс ажиллаж зам талбайг байнгын ашиглалтад хүлээн авлаа. Ингэснээр Алтанбулаг хилийн боомтын дамжин өнгөрүүлэх нэвтрэх чадвар 3 дахин сайжирч экспорт импорт нэмэгдэх нөхцөл бүрдэж байна.

Манай сумын газар тариалангийн 17 иргэн, аж ахуйн нэгжүүд 4693 га талбайд улаан буудай, 3526 га талбайд рапс болон тэжээлийн ургамал тариалсанаас Талын нурууны чиглэлд улаан буудай тариалсан “Буман хангай” ХХК, “Хүчү агро” ХХК нь 1 га-гаас дундажаар 18-20 центнер ургац 300 га талбайгаас 600 тн буудайн ургац хураан аваад байна.

Тус сум 5500 тн байгалийн хадлан бэлтгэх төлөвлөгөөтэйгээс 3250 тн байгалийн хадлан өвс бэлтгээд байна 147 иргэн, аж ахуйн нэгжүүдэд 3000 га талбайг хадлангийн зориулалтаар ашиглуулах гэрээ байгуулан ажилласан байна. Намрын ургац хураалтын ажил хур бороо элбэгтэй чийгтэй байгаагаас шалтгаалж хураалт оройтож дөнгөж 10 хувийн гүйцэтгэлтэй байна. Байгалийн хадлан бэлтгэл ажил 60 хувийн гүйцэтгэлтэй байна.

Нийгмийн халамжийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.1.5 дугаарт заасны дагуу “Ахмадын өдрийн үйлчилгээнд” Алтанбулаг сумын 63 Ахмад настан хамрагдлаа.

Мөн “Стретококкийн ангина, фарингит, хэрэх өвчин, хэрэхийн шалтгаант зүрхний олдмол гажгийг эрт оношлох” сэдэвт сургалтыг зохион байгуулж 50 хүн хамруулав.

Иргэд, хүүхэд залуучуудыг ном унших аянд уриалан дуудах, тэдний номтой харьцах соёлыг дээшлүүлэх, номыг бүтээлчээр унших аргыг түгээн дэлгэрүүлэх зорилготой “Илүү их уншъя” уриатай номын баярын арга хэмжээг зохион байгууллаа. Мөн арга хэмжээний үеэр ЕБС-ийн 1-12-р ангийн сурагчдын дунд “Номын баяр” сэдэвт гар зургийн уралдааныг зарлаж нийт 121 бүтээл ирүүлсэн байна.

#### **Баруунбүрэн сум:**

Сумын хэмжээнд 24 аж ахуй нэгж, 15 иргэн 11200 га талбайд уриншийн боловсруулалт хийж энэ онд 11148 га талбайд улаан буудай, 80 га талбайд овъёос, 50 га талбайд вандуй, 609 га талбайд тэжээлийн ургамал, 3383 га талбайд тосны ургамал, 38 иргэн 30 га талбайд төмс, 37 га талбайд хүнсний ногоо тариалсан 9 дүгээр сарын 20-ны байдлаар улаан буудайн ургац хураалт 10 хувь буюу 2230 га талбайгаас 4460 тонн ургац, рапс 69 га талбайгаас 55 тонн ургац хураан авч борлуулалт хийж, 1500 га талбай улаан буудай, 1100 га рапс ангилаад байна. Энэ жилийн хувьд хур бороо элбэг байгаа учир ургац хураалт, хадлан тэжээл бэлтгэлтийн ажил удаашралттай ургац хураалт оройтох төлөвтэй байна.

Улсын төсвийн 500,0 сая төгрөгний хөрөнгө оруулалтаар тус суманд хийгдэж байгаа “Шинэ хөдөө төсөл”-ийн ажлын явцтай сумын ажлын хэсэг танилцахад гүйцэтгэл 95 хувьтай явагдаж байна.

Сумын хэмжээнд үйл ажиллагаа эрхэлж буй худалдаа үйлчилгээний газруудын гадна, дотно талбайн тохижилт, хаягжилт, өнгө үзэмж, ажлын байрны эрүүл ахуйн шаардлага, цагийн хуваарийн мөрдөлтийг сайжруулах мөн сумын Засаг даргын 2023 оны 5 дугаар сарын 24-ний өдрийн “Хяналтын зөвлөл шинэчлэн байгуулах тухай” А/70 дугаар захирамжийн дагуу 11 хүний бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг 9 дүгээр сарын 6-8-ны өдрүүдэд Ерөнхий боловсролын сургуулийн хоол үйлдвэрлэл (Үдийн цай), дотуур байр, цэцэрлэг, эрүүл мэндийн төвийн хоол үйлдвэрлэл (гал тогоо), худалдаа үйлчилгээний 8 хүнсний дэлгүүр, хоол

үйлдвэрлэлийн чиглэлээр үйл ажиллагаа эрхлэгч 1 цайны газар, 1 гуанзаар орж хяналт шалгалтын ажлыг зохион байгуулж зөвлөмж, зөвлөгөөг өгч ажиллалаа.

Аймгийн төв Сүхбаатар суманд 9 дүгээр сарын 15, 16-ны өдрүүдэд зохион байгуулагдсан “Алтан намар үзэсгэлэн” худалдаанд айраг, цагаан идээ, зэрлэг жимс, сармис, далх бүрэн цай үйлдвэрлэгч иргэдийн төлөөлөл оролцож 7,840,500 (Долоон сая найман зуун дөчин мянга таван зуун) төгрөгийн борлуулалт хийсэн байна.

Хоршоо хөгжүүлэх сангийн хугацаа хэтэрсэн зээлдэгч нартай биечлэн уулзаж 1,250,000 (Нэг сая хоёр зуун тавин мянган төгрөг)-ийг төлүүлснээр, одоогоор 35,000,000 (Гучин таван сая төгрөг)-ний үлдэгдэлтэй байна.

Орхон аймгийн Жаргалант сум, Булган аймгийн Хангал суманд зуссан тус сумын 8 өрхийн малын тоо толгойн судалгааг гаргаж, одоогоор нүүж ирсэн 2 өрхөд хязгаарлалтын дэглэм тогтоон ажиллаж байна.

Тайлант сард цахим бүртгэлийн нэгдсэн системд хүнсэнд адуу-54 толгой, үхэр-86 толгой, хонь-108 толгой, ямаа-98 толгой нийт-346 толгой, адууны мах-926кг, үхрийн мах-1240кг, хонины мах-1640кг ямааны мах-1210кг нийт-5016кг мах, толгой-468 ширхэг тус тус бичигдсэн.

Байгаль орчныг хамгаалах тухай, Ойн тухай хууль, Байгаль орчинг аялал жуулчлалын яамны “Ой, байгалийн ургамал, ойн дагалт баялаг түүж бэлтгэх, худалдаалах, тээвэрлэх байдалд урьдчилан сэргийлэх хяналт шалгалт хийх тухай” 01/04 тоот хяналт шалгалтын удирдамж, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2023 оны 5 дугаар сарын 11-ний өдрийн А/155 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Ойн дагалт баялагийг хамгаалах, зохистой ашиглах журам”-ын хүрээнд тус сумын Ивэн 1 дүгээр баг, Бургалтайн 2 дугаар багийн нутаг дэвсгэрт Байгаль орчны хяналтын улсын байцаагч, багийн Байгаль хамгаалагч нар болон цагдаагийн албан хаагч нартай хамтран зохион байгуулахад “Ойн дагалт баялагийг хамгаалах, зохистой ашиглах журам”-ыг зөрчиж хорио тогтоосон хугацаанд Хуш модны самар түүж бэлтгэсэн 12 иргэний зөрчлийг таслан зогсоож Сайхан сум дахь Цагдаагийн хэлтсийн Экологийн асуудал хариуцсан байцаагчаар шалгуулан хялбаршуулсан журмаар шийдвэрлэн ажиллалаа.

Ивэн 1 дүгээр багийн нутаг Баян булагт намаржиж байгаа малчин Б.Отгонбаганы хотонд шөнийн цагаар хүрэн баавгай дайран орж хонь барьж идсэн тухай мэдээллийг аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын холбогдох мэргэжилтэн, Сайхан сумын гал түймэр унтраах, аврах 61 дүгээр ангид мэдэгдэж малчин өрхийг нүүлгэн шилжүүлэх арга хэмжээг авч ажиллалаа.

Ерөнхий боловсролын сургууль нь 2023-2024 оны хичээлийн жилд 51 багш, ажилчид 22 бүлэгт 540 суралцагчтайгаар сургалт хүмүүжлийн ажлаа эхлүүлээд байна. Дотуур байранд 112 суралцагч хамрагдаж байгаагаас шинээр элсэн орсон 6 настай сурагч 10, 6-9 настай 39, 10-14 настай 49, 15-аас дээш 14 сурагч байна.

9 дүгээр сарын 14-ний өдөр Цагдаагийн тасаг Ерөнхий боловсролын сургуультай хамтран дотуур байрны хүүхдүүдэд “Харилцаа ба Хандлага” сэдэвт сургалтыг зохион явуулж багш, сурагчдын төлөөлөл 39 хүнийг хамрууллаа.

Эрүүл мэндийн төв, сумын хэсгийн төлөөлөгч, сургууль хамтран “Анхны тусламж” сэдэвт сургалтыг 6-7 дугаар ангийн сурагчдад зохион явуулж 43 суралцагчдыг хамрагдлаа. Тус сургалтаар эмнэлгийн анхны тусламжийг хэрхэн хийх, болзошгүй аюулаас хэрхэн өөрийгөө хамгаалах, эрсдэлд өртсөн тохиолдолд хамгийн түрүүнд хэнд хандах гэх зэрэг мэдээллийг өгч ажилласан.

Хүний эрхийн түгээмэл тунхаглал батлагдсаны 75 жилийн ойн хүрээнд “Нэр төр, Эрх чөлөө, Шударга ёсыг хүн бүрт” уриан дор тэмдэглэн өнгөрүүлэх ажлын хүрээнд Ерөнхий боловсролын сургууль нь 2023-2024 оны хичээлийн жилийн эхний өдөр Хүний Эрхийн Түгээмэл Тунхаглалын агуулгыг тайлбарлан таниулсан хичээлд 1-12 дугаар ангийн нийт 450 гаруй суралцагч хамрагдлаа.

Нэгдүгээр цэцэрлэг нь 2023-2024 оны хичээлийн жилд 25 багш, ажилчид, үндсэн 6 бүлгийн 162 хүүхэд, хувилбарт сургалтын 43 хүүхэдтэйгээр сургалтын үйл ажиллагаагаа явуулж байна. Тус цэцэрлэг нь “Багш-эцэг эх-хүүхэд” сэдвийн хүрээнд нэгдсэн эцэг эхийн хурлыг зохион байгуулж, “Боловсрол ба эцэг эхийн оролцоо” сэдэвт сургалт зохион байгууллаа.

Илүү их уншъя уриатай “Номын баяр-2023” арга хэмжээний хүрээнд хүүхдийн уншлагыг дэмжих, номын сангийн өв санг арвижуулах, хүүхэд залууст ном эрдмийг түгээн дэлгэрүүлэхэд оршино гэсэн зорилгын хүрээнд 1-5 дугаар ангийн сурагчдын дунд “Миний мэдэх ном” гар зургийн уралдааныг зохион явуулахад нийт 27 хүүхэд оролцлоо. Мөн “Open mic” иргэд, хүүхэд багачуудийн дунд чөлөөтэй дуулах боломжийг олгосон арга хэмжээг сумын Соёлын төвөөс зохион байгуулахад 8 хүн оролцлоо.

9 дүгээр сард өвөлжилтийн бэлтгэл ажлыг хангах хадлан тэжээл бэлтгэхтэй холбоотой малын тоо толгойн албан татварын өрийн барагдуулалт нэмэгдэж 2021 оны өр 15499,1 мян.төгрөг байснаас 13256,3 мян.төгрөг болж 14,5 хувь, 2022 оны өр 62898,5 мян.төгрөг байснаас 52333,8 мян.төгрөг болж 16,8 хувиар тус тус буурч сумын орлого 148,4 хувьтай байна.

Төрийн байгууллагаас иргэн, хуулийн этгээдэд төрийн зарим үйлчилгээг үйлчилгээний нэгдсэн төвөөр дамжуулан операторын горимоор үзүүлэх үйлчилгээг e-mongolia.mn хаягаас нийт 148 иргэн 151 лавлагаа мэдээлэл, e-business.mn хаягнаас 6 аж ахуйн нэгж тоон гарын үсгээр 7 лавлагааг авсан байна. Нийт 37 иргэнд И- монгол апп-ыг хэрхэн хэрэглэх, ашиглах талаар зөвлөгөө мэдээлэл өгсөн.

Сэлэнгэ аймгийн Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар, Улаан загалмай дунд шатны хорооноос хамтран 9 дүгээр сарын 21-ний өдөр зохион байгуулж “Өдрийн үйлчилгээ”-нд 50 ахмад настнууд хамрагдлаа.

#### **Баянгол сум:**

Нийтээр тэмдэглэх баярын тухай хуулийг хэрэгжүүлэх, улс орон даяар зохион байгуулж буй номын баярыг сумын хэмжээнд өргөн дэлгэр тэмдэглэн өнгөрүүлэх, зорилгоор аймгийн нийтийн номын сангаас ирсэн удирдамжийн дагуу “Илүү их уншъя” уриан дор “Номын баяр-2023” арга хэмжээг ЕБС-ийн номын сантай хамтран “Задгай номын сан” уншлагын танхимын үйлчилгээ, “Бид номын сайн нөхөр” үзэсгэлэн, “Онсон өртөө” ардын аман зохиолын арга хэмжээг зохион байгуулан ажиллалаа.

Золбин нохой, муур устгах ажлыг 5 хоногийн хугацаанд зохион байгуулж 38 нохойг устгаж хот тохижилтын албан хаагчидтай хамтран сумын төв хогийн цэгт булшлаж ажиллалаа.

Тарваган тахал өвчний тохиолдол улсын хэмжээнд 3 аймагт бүртгэгдсэнтэй холбогдуулан сумын Баян 2 дугаар баг Хустайн даваа, өндөр улаан, Углуу Хараа 1 дүгээр багийн Хустайн даваа, Хавчуу гэх газруудаар тогтмол эргүүл хяналт шалгалт хийж, сурталчилан ажиллаж байна.

Ургац хураалт байцаа 245 тн, лууван 27,7 тн, шар манжин 155,4 тн, хүрэн манжин 33,6 тн, сонгино 228 тн, саримс 33 тн, өргөст хэмх 10 тн, улаан лооль 5,4 тн, тарвас 22,7 тн, амтат гуа 5,8 тн, хулуу 1,8 тн чинжүү 8 тн нийт 70,6 хувь, төмс 935 тн буюу 47% хувьтай байна.

Сэлэнгэ аймгийн Засаг даргын 2023 оны 07-р сарын 26-ны өдрийн 02 албан даалгаврын дагуу өвөлжилт, хаваржилтын хүрээнд сумын аюулгүй нөөцөд бэлтгэх өвс, тэжээлийг бүрдүүлэх ажилд адуу-817, үхэр-4310, хонь-12250, ямаа-6430 бүгд 28807 толгой малыг зах зээлийн эргэлтэнд оруулах төлөвлөгөөтэй байна.

Газрын нэгдмэл сангийн ангилалаар 136,0 мянган га бэлчээрийн, 10,6 мянган га хадлангийн газартай бөгөөд одоогийн байдлаар 181 өрхийн 3226 га газарт байгалийн ургамлыг хадлангийн зориулалтаар ашиглах эрхийн бичгийг



олгож 2 аж ахуйн нэгж байгууллага 348 га, 408 малчин өрхийн 5188 га, мал бүхий 216 өрхийн 4183 га, гадны аймаг сумын 21 иргэн 835 га газарт хадлан бэлтгэдэг. Одоо байдлаар малчин болон мал бүхий 356 өрх 5143 га газарт 10564 тн өвсийг бэлтгэсэн байна.

Хоршоог хөгжүүлэх сангийн 2022 оны 08 сарын эргэн төлөлтийн хуваарийн дагуу 18 зээлдэгчийн 6,6 сая төгрөгийг сангийн дансанд төвлөрүүлсэн.

#### **Ерөө сум:**

Улсын ургацын комиссын даргын 01 дүгээр албан даалгавар, аймгийн Засаг даргын 02 тоот албан даалгаваруудын хүрээнд өвөлжилт, хаваржилтийн бэлтгэл хангахад 270 малчин, мал бүхий өрх 3210 га, бизнесийн зориулалтаар 39 иргэн 877 га талбай нийт 4017 га талбайд хадлангийн гэрээ байгуулан 1850 тн хадлан бэлтгээд байна.

Мөн намрын ургац хураалт, хадлан тэжээл өвөлжилтийн бэлтгэл хангах их ажлыг цаг хугацаанд нь саадгүй тээвэрлэхэд анхаарч ургацын зам засварыг Ерөө суманд уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг “Хандгайт гол” ХХК нийгмийн хариуцлагын хүрээнд сумын төвөөс Баянголын гүүр хүртэлх 27,5 км, тасгийн жижиг гүүр хүртэлх 1,5 км шороон замыг авто гриедирээр хусаж түрэх ажлыг хийж гүйцэтгэсэн.

Улаан буудай ангилан-400 га, шууд хураалт 840 га талбайгаас 1382 тн будаа, арвай 77 га талбайгаас 85 тн, рапс 678 га талбайг тус тус ангилсан байна. Төмс 5 га талбайгаас 50 тн, хүнсний ногоо 32,8 га талбайгаас 341 тн хураан аваад байна.

Засгийн газрын 279 тоот тогтоолын хүрээнд энэ онд бизнесийн зориулалтаар хадлан бэлтгэж буй иргэдийн гэрээний үүргийн дагуу сумын өвс, тэжээлийн аюулгүйн фонд бүрдүүлэхээр 1 га талбайгаас 2 боодол өвс бэлтгүүлэхээр зааж 30 тн тэжээлийг газар тариалангийн аж ахуйн нэгжүүдтэй нийгмийн хариуцлагын хүрээнд бэлтгүүлэхээр албан тоот хүргүүлэн ажиллаж байна.

Сумын Засаг даргын А/232 дугаар захирамжаар Бруцеллэз өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад 25840 толгой бог, бодын төлийг хамруулахаар төлөвлөсөн гүйцэтгэл 15761 буюу 61 хувьтай явагдаж байна.

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2023 оны 85 тоот тогтоолыг үндэслэн баталсан хуваарийн дагуу ойгоос мод бэлтгэх эрхийн бичгийг ойн цэвэрлэгээний ажлаар 55 иргэн, 2 аж ахуй нэгжид олгосон байна.

#### **Жавхлант сум:**

2023-2024 оны хичээлийн жилд Ерөнхий боловсролын сургуульд 320 хүүхэд, цэцэрлэгт 120 хүүхэд суралцаж байгаа бөгөөд 41 хүүхэд шинээр 1 дүгээр ангид элсэн суралцаж байна.

Өвөлжилт, хаваржилтын бэлтгэл ажлын хүрээнд 222 малчин өрхийн 4861 га талбайд хадлан бэлтгэлийн гэрээг хийж, гүйцэтгэл урьдчилсан байдлаар өмнөх онтой харьцуулахад 74,7 хувьтай явагдаж байна. Одоогийн байдлаар 498 малчин, мал бүхий өрхийн 215 техник хэрэгсэл, 402 иргэн хадлан бэлтгэлийн ажилд ажиллаж малчдын түвшинд 7854 тн байгалийн хадлан бэлтгэхээс 2800 тн, 30 тн хужир, 30 тн хивэг, сумын аюулгүй нөөцөд 5 тн байгалийн өвс бэлтгээд байна. Малчдын хэрэглээнд ашиглагдаж байгаа 40 гүний худаг ашиглалтад бэлэн засвар, дулаалга хийгдэж, 498 малчин, мал бүхий өрхийн 285 өвөлжөө байгаагаас дулаалгын засвар үйлчилгээ, ариутгалын ажил хүлээгдэж байна.

Төмс хүнсний ногоо 191 га талбайгаас 2409 тн ургац хурааж, ургац хураалт 53 хувьтай байна. Шарын гол, Ерөө гол, Төхөм тал ургац нөхөрлөлд 80 цэрэг, 40 оюутан, сум орон нутгийн 100 гаруй иргэн ургац хураалтад ажиллаж байна. Улаан буудайн ургац хураалт цаг агаараас шалтгаалан эхлээгүй, тосны ургамал 50 га

талбайгаас 30 тн ургац хураан авсан. Тосны ургамал 650 га ангилан хадалт хийсэн байна.

“Номын баяр-2023” арга хэмжээний хүрээнд эсгий урлалын үзэсгэлэн, “Open mic”, гар зургийн уралдаан, шүлгийн уралдаан зэрэг зохион байгуулагдаж 275 сурагчид хамрагдлаа. Мөн Ерөө бүсийн соёлын ажилчдын “Бүс нутгийн соёлын сэргэлт-Соёлын орон зай” уулзалт өдөрлөгийн хүрээнд “Соёлын ажилтнуудын ажиллах орчин, нөхцөл, цалин хөлс, нийгмийн баталгааг сайжруулах эрх зүйн шинэчлэл” сургалт, хэлэлцүүлгийг зохион байгууллаа.

#### **Зүүнбүрэн сум:**

Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас Улаанбаатар хотод зохион байгуулагдсан “Намрын ногоон өдрүүд-2023” үзэсгэлэн худалдаанд сумын 15 ногоочин оролцож 36,8 сая төгрөгийн борлуулалт хийсэн. Мөн “Сэлэнгэ Алтан намар-2023” үзэсгэлэн худалдаанд сумын төлөөлөл 15 төрлийн бүтээгдэхүүнээр оролцож 4,5 сая төгрөгийн борлуулалт хийлээ.

Сумын хэмжээнд 228 иргэн, 1 аж ахуй нэгжтэй 3409 га талбайд хадлангийн газар ашиглуулах гэрээ байгуулан ашиглуулж хадлан бэлтгэл 60 гаруй хувь буюу 4800 тн өвс, өвөлжилтийн бэлтгэл ажлын хүрээнд нөөц бүрдүүлэх зорилгоор 60 иргэнтэй 3000 гаруй боодол өвс бэлтгэх гэрээ байгуулсан.

Улаанбуудай 1200 га-с 2000 тн, арвай 435 га-с 1130 тн хурааж ургац хураалт 16,4 хувьтай, төмс 25 га-с 210 тн, хүнсний ногоо 199 га-с 2100 тн хурааж хураалт 62,5 хувьтай явагдаж байна.

“Ви И Ти Нэт” төрийн бус байгууллагаас жил бүр зохион байгуулдаг “Хайрын бэлэг” төсөлд сумын зорилтот 10 өрхийг хамруулан өрх тус бүрд 3 хонь хүлээлгэн өгөх ажлыг зохион байгууллаа.

Сэлэнгэ аймгийн статистикийн хэлтсээс багийн өрхүүдээс түүврийн аргаар 10 өрх сонгогдсоны 8 өрх өрхийн хэрэглээ, амьжиргааны түвшин, ажилгүйдлийн түвшин тодорхойлох судалгаанд хамрагдсан.

Өвөлжилтийн бэлтгэл ажлын хүрээнд үерийн усанд эвдэрч машин техник явах боломжгүй болсон “Орос даваа”, “Найдварын гуу” зэрэг зам давааг засварллаа.

2023-2024 оны хичээлийн жилд 1 дүгээр ангид 55 сурагч элсэн, бага боловсролын 9 багш, 1-5 дугаар ангийн 272 сурагч, дунд болон ахлах ангид мэргэжлийн 13 багш дунд ангийн 7 бүлгийн 208, ахлах ангийн 3 бүлгийн 78, нийт 10 бүлгийн 286 сурагч, нийт 558 суралцагчтай хичээл сургалтын үйл ажиллагаа явагдаж байна.

#### **Мандал сум:**

Сумын хэмжээнд 2023-2024 оны хичээлийн жилд 7-н сургууль, 7 цэцэрлэг, Сургууль цэцэрлэгийн цогцолбор 1, Политехник коллеж зэрэг боловсролын 16 байгууллага сургалт хүмүүжлийн үйл ажиллагаа явуулж байна. Энэ хичээлийн жилд Ерөнхий боловсролын 1 дүгээр ангид шинээр 557 сурагч элсэн суралцаж байгаа ба нийт 6051 хүүхэд Ерөнхий боловсролын сургуульд, сургуулийн өмнөх боловсролын 8 цэцэрлэгт нийт 1687 хүүхэд суралцахаар хичээлийн шинэ жилийг эхлүүллээ.

Монгол Улсын Хүнсний манлай үйлдвэрүүдийн нэг “Алтан тариа” ХХК нь Мандал сумын Ерөнхий боловсролын 1-дүгээр сургуулийн номын сангийн танхимыг орчин цагийн шийдэлд нийцүүлэн иж бүрэн тохижуулж хүүхэд багачууд сурч хүмүүжих таатай орчин нөхцөлийг бүрдүүлэн номын фондыг нь нэмэгдүүлэн хөрөнгө оруулалт хийлээ.

Сэлэнгэ аймгийн Хүүхдийн зөвлөлөөс 6 сум, 1 тосгоныг хамруулан зохион байгуулсан “OPEN STAGE” нээлттэй тайзны үйл ажиллагааг 9 дүгээр сарын 12-ны өдөр Мандал суманд зохион байгуулж 5 сургуулийн 100 гаруй сурагчид оролцлоо.

Австралийн Элчин Сайдын яам, Монгол Улсын Үндэсний Номын Сан, Монголын Номын Сангийн Холбоо хамтран хэрэгжүүлж буй "ХИЛ ХЯЗГААРГҮЙ НОМЫН САН" төслийн баг сумын Нийтийн номын сангын хүүхдийн уншлагын танхимын номын фондод 2,014,900 төгрөгийн үнэ бүхий номыг хандивлаж баяжилт хийлээ.

Мод бэлтгэлийн талбай тусгаарлалт хийлгэх 2 аж ахуй нэгж байгууллага хүсэлт гаргасаны дагуу цэвэрлэгээний ажлаар 35 га 2 цэгт талбайд тусгаарлалтын ажлыг хийж гүйцэтгэсэн. Мод бэлтгэлийн чиглэлээр 2 ААНБ 119м<sup>3</sup> хэрэглээ, 20 м<sup>3</sup> түлээ, 4 аж ахуй нэгж байгууллагын ойн сангаас 9 иргэнд 66 м<sup>3</sup> түлээний мод бэлтгэх эрхийн бичгийг тус тус олгосон. Мөн УБТЗ МБҮ-ийн 99м<sup>3</sup> дэр мод, 61,5 м<sup>3</sup> түлшний зах банз, 8 аж ахуй нэгж байгууллагын 170м<sup>3</sup> хэрэглээний модонд тус тус нийт гарал үүслийн гэрчилгээг олгосон.

Европын Холбоо, ХБНГУ-ын Эдийн засгийн хамтын ажиллагаа хөгжлийн яам (BMZ)-ны хамтарсан санхүүжилттэйгээр хэрэгжиж буй "Хөдөө ахуйн менежмент, экосистемийн тогтвортой байдлыг хангах "STREAM" төслийн Ойн бүрэлдэхүүн хэсэг, БНЧУ-ын Менделийн их сургууль тэргүүтэй их сургуулиудын консорциумтай хамтран "Ойчидтой нэг өдөр" өдөрлөгийг зохион байгуулж ерөнхий болосвролын 5 сургуулийн 50 сурагчдад хамрууллаа.

"Намрын ногоон өдрүүд", "Үндэсний үйлдвэрлэл-2023" нэгдсэн арга хэмжээ Улаанбаатар хотод 9 дүгээр сарын 20-26-ны өдрүүдэд төв цэнгэлдэх хүрээлэнд зохион байгуулагдаж 18 ногоочид 10 төрлийн хүнсний ногоогоор оролцож байна.

Мөн баялаг бүтээгчдийн үйлдвэрлэсэн бараа бүтээгдэхүүнийг сурталчлах, брэнд бүтээгдэхүүний үйлдвэрлэл дотоодын худалдан авалтыг нэмэгдүүлж, зах зээлийг өргөтгөн борлуулалтад дэмжлэг үзүүлэх зорилгоор аймгийн төв Сүхбаатар хотод "Сэлэнгэ Алтан намар-2023" үзэсгэлэн худалдаа 9 дүгээр сарын 15, 16-ны өдрүүдэд зохион байгуулагдлаа. Тус үзэсгэлэн худалдаанд сумын баялаг бүтээгчдийн төлөөлөл хүнс, хөнгөн үйлдвэрлэл, гар урлал, талх нарийн боов, төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэнэ, даршилсан ногоо, хатаасан хоол амтлагч, бордоо зэрэг бүтээгдэхүүнүүдээрээ оролцлоо.

Монгол Улсын Засгийн газраас авч хэрэгжүүлж байгаа Хөдөөгийн сэргэлтийн бодлогын хүрээнд Хүнс, хөдөө аж ахуйн салбарыг дэмжих хөнгөлттэй зээлийн талаар орон нутагт үйл ажиллагаа явуулдаг арилжааны банкны захирлуудтай цаг үеийн мэдээлэл солилцлоо. Зүүнхараа Хаан банкны зүгээс эргэлтийн хөрөнгийн 4 төрлийн 2,6 тэрбум төгрөгийн зээл, хөрөнгө оруулалтын 2 төрлийн 111 сая 750 мянган төгрөгийн зээл нийт 2.7 тэрбум төгрөгийн зээлийг үйлдвэрлэл эрхлэгчдэд олгожээ. Бусад банкны зээл олголтын судалгаа хийгдэж байна.

УБТЗ-ын харьяа Зүүнхараа БАҮ-ий 1 дүгээр анги нь Мандал суманд халаалтын 4 уурын зуухаар 71 аж ахуйн нэгж байгууллага, 900 гаруй айл өрхийг халаалт дулаанаар ханган ажилладаг. Төлөвлөгөөт шугам засварын ажлууд дуусч 9 дүгээр сарын 15-ны өдрөөс аж ахуйн нэгж байгууллага, айл өрхийн халаалт дулааныг өгсөн.

#### **Орхонтуул сум:**

Хамтарсан багийн "Орхонтуул сум Хамтарсан баг" Фэйсбүүк хуудсаар дамжуулан Гэр бүлийн хүчирхийллийн тухай хууль, Хүүхдийн эрхийн тухай, Хүүхэд хамгааллын тухай хууль, тогтоомж, Хүүхдийг эрсдэлээс хамгаалах, урьдчилан сэргийлэх зөвлөмж, хүүхэд хүмүүжүүлэх эерэг арга, гэр бүлийн хүчирхийлэл түүнээс урьдчилан сэргийлэх шторк мэдээллийг тогтмол түгээн иргэдийг мэдээ мэдээллээр ханган ажиллаж байна. 108 дуудлагын утсанд энэ сард 2 дуудлага бүртгэгдэж шийдвэрлэсэн. Гэр бүлийн хүчирхийллийн 1 өргөдөл ирж хамтарсан багаар хуралдан газар дээр нь ажиллаж нөхцөл байдлын үнэлгээ хийн цагдаагийн байгууллагад шилжүүлжээ.

Аймгийн төв Сүхбаатар суманд зохион байгуулагдсан "Намрын ногоон өдрүүд-2023" арга хэмжээнд сумын төлөөлөл хүнсний ногоо тариалдаг иргэд оролцсон байна. Сумын Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгө оруулалтаар "Баянцогт 2-р багийн 1 орцтой барилгын дээвэр засвар, орцны хаалга шинэчлэх" ажлын гүйцэтгэл 100 хувьд хүрч ажлын хэсэг хүлээн аваад байна

Мөн "Баянцогт 2-р багийн 2 орцтой барилгын дээвэр засвар, орцны хаалга шинэчлэх" ажлын гүйцэтгэл 60 хувьтай явагдаж, гүйцэтгэлд хяналт тавин ажиллаж байна.

Сумын засаг даргын 2023 оны 08 дугаар сарын 21-ний өдрийн А-127 дугаар захирамжийн дагуу тугал, хурга ишгийг бруцеллээс өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтанд 59520 толгой төл хамруулахаас 35024 толгойг хамруулж вакцинжуулалтын ажил 58,8 хувьтай явагдаж байна.

Уул уурхайн чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуйн нэгжүүдэд Сумын засаг даргаар ахлуулсан ажлын хэсгийн хүрээн хяналт шалгалт хийж хуулын чиглээр заавар зөвлөгөө өгж ажилсан. 2023 оны 09 сард байгаль орчны албатай холбоотой 7 албан тоот ирсэн уг албан тоотуудын ихэнх нь Онцгой байдлын газартай холбогдуулан шаардлагатай арга хэмжээ зохион байгуулах ажлын хүрээнд 3 хариутай бичгийг холбогдох газруудад хүргүүлсэн. Сумын засаг даргын захирамжаар батлагдсан ажлын хэсгийн хүрээнд сумын хэмжээнд зөвшөөрөлгүй зусаж, намаржиж байгаа айл өрхүүдэд бэлчээр чөлөөлөх мэдэгдэл хүргүүлж бэлчээр ашигласаны төлбөр тооцоог барагдуулан ажиллаж байна .

#### **Орхон сум:**

Бүгд Найрамдах Солонгос Улсын Хадун сум, Орхон сум хоорондын хамтын ажиллагааны хүрээнд хөдөө аж ахуйн салбарт улирлын чанартай ажилтан солилцох гэрээний дагуу тус улсаас 2 төлөөлөгч хүрэлцэн ирж, салбарын үйл ажиллагаа, одоогийн нөхцөл байдалтай танилцлаа.

Тус сумын Ерөнхий боловсролын сургуулийн түүхт 70 жилийн ой 9 дүгээр сарын 22,23-ны өдрүүдэд зохион байгуулагдаж, үе үеийн төгсөгчид, эрдэмтэн багш нар, ажилтан, албан хаагчдын 750 гаруй зочид төлөөлөгчид хүрэлцэн ирж оролцлоо. Ойн баярын хүрээнд бэсрэг наадам зохион байгуулагдаж 3 насны 27 хурдан морь уралдаж, 32 бөх зодоглолоо.

Бүх нийтийн хог цэвэрлэгээний хуваарийн дагуу 9 дүгээр сарын 20-ны өдөр "Бүх нийтийн цэвэрлэгээ"-г зохион байгуулж, төр төсвийн 5 байгууллагын 56 ажилтан, албан хаагч, 6-12 ангийн 92 сурагч, 10 иргэн оролцож сумын төвийн нийтийн эзэмшлийн гудамж талбай, Дархан-Эрдэнэтийн засмал зам, угтах хаалганаас гүүр хүртэлх 12 га талбайн 2 тн хог хаягдлыг цэвэрлэлээ.

Сэлэнгэ аймгийн Сайхан сумын нутаг дэвсгэрт хориотой үед зөвшөөрөлгүй хуш модны самар тээвэрлэж явсан 3 иргэнд тус бүр 300.000 төгрөгийн торгуулийн арга хэмжээ тооцож 852 кг самрыг хурааж улсын орлого болгосон.

Сумын хэмжээнд нийт 13423 га талбайд тариалалт хийснээс улаан буудай 6154 га, овъёос 60 га, арвай 10 га, тэжээлийн ургамал 718 га, тосны ургамал 5024 га, төмс 627 га, хүнсний ногоо 830 га талбайд тус тус тариалсан. Ангилсан талбайн улаан буудай 2872 га, тосны ургамал 670 га, цайруулсан талбай улаан буудай 240 га талбайгаас 288 тн, тосны ургамал 200 га талбайгаас 200 тн ургац хураан авсан. Төмсний ургац хураалт 550 га талбайгаас 6500 тн, хүнсний ногоо 500 га талбайгаас 700 тн ургац хураан аваад байна.

#### **Сант сум:**

Сант суманд 2021 оноос хэрэгжсэн "Дэлхийн зөн Монгол" Олон Улсын байгууллагын "Сэлэнгэ Орон нутгийн хөтөлбөр"-ийн төгсөлтийн аргачлал хөтөлбөрт хамрагдаж төгссөн 20 өрхийн "Үр дүнгийн баяр" арга хэмжээг 9 дүгээр сарын 14-ний өдөр зохион байгуулагдлаа. Тус хөтөлбөрийн үр дүнг үнэлж, оролцсон өрхүүдийг шалгаруулж урамшууллаа.

Аймгийн төв Сүхбаатар суманд 9 дүгээр сарын 15,16-ны өдрүүдэд зохион байгуулагдсан “Алтан намар” үзэсгэлэн худалдаанд 1 хоршоо, 6 иргэн цагаан идээ, жимсний чанамал, чацарганы жүүс, дарсан ногоо, вакумлаж савласан органик ногоо, суран эдлэл зэрэг бүтээгдэхүүнээр оролцож 2,383,500 төгрөгийн борлуулалт хийлээ.

Өвөлжилтийн бэлтгэл ажлын хүрээнд 407 иргэнд 1947 м.куб түлээ, 48 иргэнд 174 м.куб хэрэглээний мод бэлтгэх эрхийн бичиг олгож, ойн нөөцийн орлого 9,090,950, нөхөн сэргээлтийн зардалд 3,608,000, талбай тусгааралтын төлбөрт 926,000, улсын тэмдэгтийн хураамжид 809,000 төгрөгийн орлого төвлөрүүллээ. Иргэдийн түлээ бэлтгэлийн ажил 80 гаруй хувьтай явагдаж байна.

Сумын ЗДТГ-ын даргаар ахлуулсан ажлын хэсэг сургууль, цэцэрлэгийн хоол үйлдвэрлэлт, хүнсний хадгалалт хамгаалалтанд хяналт шалгалт хийж зөвлөн туслах үйлчилгээ үзүүллээ. Хяналт шалгалтын явцад илэрсэн нийтлэг зөрчлийг арилгуулах талаар байгууллагын удирдлагуудад шаардлага тавьж ажиллаж байна.

Ойн тухай хууль зөрчиж мод бэлтгэсэн 2 зөрчил илрүүлж 1 зөрчилд 50,000 төгрөгийн торгууль, 19074 төгрөгийн нөхөн төлбөр оногдуулж, 1 зөрчлийг хууль хяналтын байгууллагад шилжүүллээ.

Улс төрийн хилс хэрэгт хэлмэгдэгчдийн дурсгалыг хүндэтгэх өдрийг тохиолдуулан 7-12-р ангийн сурагчдын дунд “Улс төрийн хэлмэгдүүлэлт, түүний хор уршиг, шалтгаан нөхцөл, түүнийг дахин гаргахгүй байх арга зам”-ын тухай лекц, яриа таниулгыг хийж, АХА тэмцээн зохион байгууллаа.

#### **Сайхан сум:**

Тайлант сард сумын нийт малчин, мал бүхий иргэдэд хэрэглээний хадлангийн талбайг харьяалагдах багийн Засаг дарга, ажлын хэсгийг тухайн газарт нь биечлэн очиж хуваарилалтыг зохион байгуулж, хадлангийн талбай ашиглалтын талаар гэрээ байгуулан, газрын төлбөрийг төрийн санд төвлөрүүлэн ажиллалаа. Сумын хэмжээнд нийт 186 иргэний өргөдлийг шийдвэрлэж 3460 га хадлангийн талбайг нэг жилийн хугацаатай ашиглалтаар олгосон.

Мөн сумын өвс, тэжээлийн аюулгүйн нөөцийг Хадлангийн талбайн ашиглалтын гэрээний 4.1 дэх заалтад заасны дагуу тухайн гэрээ байгуулсан малчин, мал бүхий иргэд тодорхой тооны өвс тушаахаар эсвэл нэг боодол өвсийг зах зээлийн үнээр 5000 төгрөг гэж тооцон харилцан тохиролцож ЗДТГ-т нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрүүлсэн. Одоогоор гэрээ байгуулсан иргэн 120 орчим үлдсэн иргэд гэрээг байгуулаагүй байна.

Хадсан талбай - 1815 га (задгайгаар буюу бухал бэлтгэсэн 415 га, боодлоор буюу прэссэлсэн 800 га , баллдаж бэлтгэсэн 600 га) нийт 2450 тонн хадлангийн өвс бэлтгэсэн байна.

“Алтан намар”-2023 үзэсгэлэн худалдаанд 2 аж ахуйн нэгж, 6 иргэний үйлдвэрлэсэн 30 гаруй нэр төрлийн сумын брэнд бүтээгдэхүүнээр оролцож шууд худалдан борлуулалт хийж амжилттай оролцлоо.

Хоршоог хөгжүүлэх сангийн дансанд 198,848,862 төгрөгийг төвлөрүүлэн ажиллалаа.

Нийтээр тэмдэглэх баярын тухай хуулийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд улс орон даяар зохион байгуулж буй; Үндэсний бичиг соёл, номын өдрүүд; Номын баярыг Номгон тосгоны хэмжээнд өргөн цар хүрээтэй тэмдэглэн өнгөрүүлж, хүүхдийн уншлагыг дэмжих, хүүхэд залууст ном, эрдмийг түгээн дэлгэрүүлэх зорилгоор гар зургийн уралдаан, “Open mic” арга хэмжээ, задгай номын номын сан, худалдаа, үзэсгэлэн, ховор ном судар үзэсгэлэн гаргах, бүтээлч хүүхэд, “Онъсон өртөө” ардын аман зохиолын арга хэмжээг тус тус зохион байгууллаа.

Сэлэнгэ аймгийн нийтийн номын сангаас Австралийн Элчин Сайдын яам, Монгол Үндэсний номын сан, Монголын Номын сангийн холбоотой хамтран зохион

байгуулж буй “Хил хязгааргүй номын сан” сэдэвт сургалтад сумын сургууль, соёлын ордон, соёлын төвийн номын санчдыг бүрэн хамруулав.

### **Сүхбаатар сум:**

Суманд үйл ажиллагаа явуулж буй 4 хийд, 10 сүмд батлагдсан удирдамжийн дагуу хяналт шалгалтын ажил зохион байгуулж, илэрсэн зөрчил, дутагдалыг арилгах чиглэлээр үүрэг чиглэл өгч ажилласан.

Мөн төр төсвийн байгууллагуудын дунд “Ёс зүйн зөрчилгүй сум” аяныг эхлүүлж ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэг, өрхийн эрүүл мэндийн төвүүдийн удирдлагууд болон тухайн байгууллагын ёс зүйн зөвлөлийн дарга нар оролцлоо.

2023-2024 оны шинэ хичээлийн жилд тус сумын Ерөнхий боловсролын бүрэн дунд сургуулийн 1-р ангид 448 хүүхэд шинээр элсэн орж 5266 хүүхэд ерөнхий боловсролын сургуульд хамрагдан суралцаж 264 багш ажиллаж, сургуулийн өмнөх боловсролын байгууллагад нийт хамрагдвал зохих хүүхдийн 1890 хүүхэд цэцэрлэгт хамрагдаж 5 настан бүрэн хамрагдсан.

Өрхийн эрүүл мэндийн төвүүд нь “Эхийн сүүгээр хооллолтыг дэмжих” долоо хоногийн ажлын хүрээнд байгууллагын фэйсбүүк хуудсанд эхийн сүүгээр хооллолтын ач холбогдлын талаар мэдээлэл бэлтгэн цахим орчинд байршуулж, суманд үйл ажиллагаа явуулж буй албан байгууллагуудад “Хөхүүл эхэд ээлтэй ажлын байр” бий болгох талаар уриалан ажилласан.

Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний хүрээнд сумын хөрөнгө оруулалтаар тусгай хэрэгцээт хүүхэд хүлээн авдаг 6 дугаар цэцэрлэгт 19,000,000 төгрөгийн санхүүжилтээр сэргээн засах тоног төхөөрөмж авсан.

Сумын Амьжиргаа дэмжих зөвлөл хуралдаж, байнгын асаргааны сунгалт 23 иргэн, байнгын асаргаанд шинээр 17 иргэн, өрх толгойлсон 2 иргэн, түлээ нүүрсний хөнгөлөлтөд 9 ахмад настан, тэжээгчээ алдсан 1 иргэн, нийт 61 иргэний бичиг баримтыг хэлэлцэн шийдвэрлэсэн.

Сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын Тамгын газар, Хүүхдийн зөвлөл хамтран “OPEN STAGE” нээлттэй тайзны үйл ажиллагаа зохион байгуулсан. “OPEN STAGE” үйл ажиллагаанд нийт 23 хүүхэд оролцож, үүнээс 16 хүүхэд дуулж, 7 хүүхэд бүжиглэж өөрсдийн авьяасаа үе тэнгийхэндээ үзүүлсэн.

Дэлхийн Зөн Монгол Олон Улсын байгууллагын Сэлэнгэ орон нутгийн хөгжлийн хөтөлбөр, Засаг даргын Тамгын газар хамтран “Төгсөлтийн аргачлал” төсөлд хамрагдсан 40 өрхийн тайлант өдөрлөгийн зохион байгуулсан.

Тус сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгч, Засаг даргын Тамгын газар хамтран 1 дүгээр багийн иргэдийн дунд 3х3 сагсан бөмбөгийн аварга шалгаруулах тэмцээн, 5, 8 дугаар багийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Төлөөлөгчид, Сүхбаатар сумын Ахмадын хороо нь хамтран ахмад настнуудын дунд хийн дасгалын тэмцээн тус тус зохион байгуулсан.

Сумын Засаг даргын 2023 оны “Ургацын хохирол тогтоох, ургац тогтоолтын ажил зохион байгуулах тухай” А/283 дугаар захирамжийн хүрээнд ургац тогтоолтын баланс гаргаж, сумын хэмжээнд төмс 105,8 цн, хүнсний ногоо 110,2 цн хураан авах баланс тогтоож, төмс 243,34 тн, хүнсний ногоо 226,28 тн тус тус хураан авч, Ургац хураалт 52 хувьтай явагдаж байна.

Манай суманд зохион байгуулсан “Сэлэнгэ алтан намар-2023” үзэсгэлэн худалдаанд төмс, хүнсний ногооны тариалан эрхлэгч 9 иргэн 32 нэр төрлийн бүтээгдэхүүнээр оролцож 7,600,000 сая төгрөг, жижиг дунд үйлдвэр эрхлэгч 25 иргэн, аж ахуйн нэгж, 44 нэр төрлийн бүтээгдэхүүнээр оролцож, 13,190,000 төгрөг, сумын хэмжээнд нийт 34 иргэн 76 нэр төрлийн 20,790,000 төгрөгийн борлуулалт хийсэн.

Мөн Улаанбаатар хотын төв цэнгэлдэх хүрээлэнд 9 дүгээр сарын 20-26-ны өдрийг хүртэл зохион байгуулагдах “Намрын ногоон өдрүүд үндэсний үйлдвэрлэл-

2023” үзэсгэлэн худалдаанд төмс, хүнсний ногооны тариалан эрхлэгч 6 иргэн оролцож байна.

Сумын Засаг даргын 2023 оны “Хөл газрын ургамал устгах тухай” А/270 дугаар захирамжийн хүрээнд тус суманд үйл ажиллагаа явуулж буй төр төсвийн 12 байгууллага, хувийн хэвшлийн 77 аж ахуй нэгж, байгууллага, 142 өрх гудамж, зам талбайн хог хаягдал, шарилж устгалын ажлыг хийж гүйцэтгэсэн.

“Өргөн-Сэлэнгэ үйлчилгээ” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газар нь “Гэрэлт цогцолбор”-ын ногоон байгууламжийн арчилгааг хийж ургалт нь зогсож шарласан нарсны тарьц суулгац болон иргэдийн үүсгэсэн хог хаягдлыг цэвэрлэж төвлөрүүлэн хогийн цэгт хаясан.

Иргэдийн аюулгүй байдлыг хангах ажлын хүрээнд 100-н эзэнгүй, уяа хамгаалалтгүй золбин нохойг сумын Засаг даргын нөөц хөрөнгөөс 2,100,000 төгрөгийн зардал гарган устгах ажлыг зохион байгуулсан.

Сүхбаатар сумын хэмжээнд өвөлжилтийн бэлтгэл хангах ажлын хүрээнд Алтанбулаг сумаас 10-н иргэнд 50м<sup>3</sup>, Хүдэр сумаас 5-н иргэнд 52м<sup>3</sup> модыг ойн цэвэрлэгээний ажлаас түлээний зориулалтаар иргэдэд олгосон.

Тус сумын малчин иргэдэд хадлан тэжээл бэлтгэх шаардлага тулгарч байгаатай холбогдуулан “Тужийн нарсны байгалийн цогцолбор” газрын хамгаалалтын захиргаатай хамтран ажиллах гэрээний дагуу нийт 20-н иргэнтэй хадлан тэжээл бэлтгэх гэрээ байгуулсан. Мөн нийтийг хамарсан ажлын хүрээнд 8 багийн хэмжээнд хашаа буулгах, барих, ногоон байгууламж, мод бут хэлбэржүүлэх ажилд 15 иргэнтэй гэрээ байгуулан 10 хоногийн хугацаатай ажиллуулж байна.

Аймгийн стандарт хэмжил зүйн хэлтэстэй хамтран худалдаа, үйлчилгээний байгууллагын стандартыг мөрдүүлэх, хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангуулах хяналт шалгалтын ажлыг удирдамжийн дагуу 9 дүгээр сарын 7-12-ны өдрүүдэд зохион байгуулж, зөвлөн туслах үйлчилгээ үзүүлсэн.

Улс орон даяар 5 жил тутам зохион байгуулагддаг Нийгмийн үзүүлэлтийн түүвэр судалгааны бэлтгэл ажлын хүрээнд сонгогдсон 2, 4, 5, 6, 8 дугаар багуудын нийт 1000 өрхийн тодруулгыг хийж хугацаанд нь хүлээлгэн өгсөн. Мөн “Амьдрах орчны аюулгүй байдлын судалгаа”-д сонгогдсон 2, 4 багуудад нийт 393 өрхийн тодруулгыг хийж хугацаанд нь хүлээлгэн өгсөн.

#### **Түшиг сум:**

2023-2024 оны хичээлийн шинэ жилд ерөнхий боловсролын сургуульд 1 дүгээр ангид шинээр 30 сурагч элсэн, нийт 360 суралцагчтай байна.

Мөн 5 бүлэгт нийт 150 хүүхдийг хүлээн авч сургалтын үйл ажиллагаа хэвийн явагдаж байна. Өдөр тутмын сургалт үйл ажиллагаанд эрхлэгч, арга зүйч нар сууж үйл ажиллагааг тогтмолжуулах, сайжруулах тал дээр анхаарч ажиллаж байна. “Боловсролын шинэчлэл- 2023”-сэдэвт цахим сургалтад эрхлэгч, арга зүйч, багш нар хамрагдсан. Мөн боловсролын ерөнхий хуулийн талаарх мэдээллийг эрхлэгч сургалтаар зохион байгууллаа. Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын сайдын 2020 оны 6 сарын 2-ны өдрийн А/280 дугаар тушаалын дагуу “Сургуульд бэлтгэгдсэн байдлын үнэлгээ”-г амжилттай зохион байгуулж ЕБСургуулийн үнэлгээний багтай хамтран ажиллаа.

“Хоггүй Түшиг” аян бүх нийтийн их цэвэрлэгээ айл өрх, аж ахуйн нэгж байгууллагууд орчны 50м газрын хог хаягдал болон шарилж хогийн ургамалыг цэвэрлэх аяныг өрнүүлж амжилттай зохион байгууллаа.

Хуурайшилтын үе эхэлсэн тул мод бэлтгэлийн ажлыг бүрэн зогсоосон. “ММЭ түшиг” ХХК, “Мойлт нуга” ХХК-ийн 2 талбайд мод бэлтгэл тээвэрлэлт хяналтын хуудас гадагш тээвэрлэж буй мод модон материалд гарал үүслийн гэрчилгээ олгож хяналт тавьж ажилласан. Байгаль орчны аялал жуулчлалын яам ойн газрын ажлын хэсгийн хамт мэргэжлийн байгууллагуудын үйл ажиллагаанд үнэлэлт дүгнэлт өгөх удирдамжийн дагуу хяналт шалгалт хийгдсэн.

Малчид тариаланчдын зөвлөгөөнийг зохион байгуулан ажиллан цаашид аж ахуйн нэгжүүд малчин өрхүүд хамтран ажиллах шийдвэрүүд гарсан. Нийт 7 аж ахуй нэгж 2 иргэний тариан талбайд ургац тогтоолтын ажлыг зохион байгуулан сумын хэмжээнд нийт үр тариа 18,9 цн ургац хураан авах төлөвтэй байна. Хүнсний ногооны хураалт 77,4 хувьтай байна. Мөн төмс 35,5 хувьтай хураалт явагдаж байна. Сумын 100 жилийн ойтой холбогдуулан 12 боодол тариан түрүү бэлтгэн авч 2 аж ахуйн нэгжид 20 ширхэг тариан түрүү бэлтгэн ажлыг даалган ажилласан.

#### **Хушаат сум:**

Ахмадын баярыг угтан “Дуундаа жаргасан ахмадууд” дуун цэнгүүнийг амжилттай зохион байгуулж 42 ахмад оролцлоо.

2023-2024 оны хичээлийн жилд ЕБС нийт 4 удирдлага, 21 багш, 20 ажилчидтай сургалт хүмүүжлийн үйл ажиллагаа явуулан ажиллаж байна. Ардын аман зохиолыг тааж, оньс тайлах уралдааныг оньсон тоглоом, ертөнцийн гурвыг зохиолгох, үг бүтээх, оньсого таах, өвөрмөц үгийн утгыг тайлбарлах өртөөчилсөн “Оньсон өртөө” уралдаануудыг зохион байгууллаа. Мөн 1-12-р ангийн сурагчдын дунд насны ангилалаар “Номын баяр” сэдэвт гар зургийн уралдаанд нийт 68 хүүхэд оролцлоо.

2023 оны хавар худалдан авсан бордооны 50 хувийг төрөөс буцаан олгож байгаатай холбоотой 5 аж ауйн нэгжийн бордооны хүсэлтийг plant.mofa.gov.mn цахим бүртгэлээр нь илгээж өгсөн. Мөн 3 аж ахуйн нэгжид цахим бүртгэлийн талаар зөвлөгөө өгсөн. 9 сарын байдлаар улаанбуудай 802 га-аас 983тн, рапс1071га ангилсан, төмс 36 га-аас 250тн, хүнсний ногоо 53,4 га-аас 1200,8 тн ургац хураан авсан байна.

Хоршоо хөгжүүлэх сангийн эргэн төлөлт 9 сарын байдлаар 529,400 төлөгдсөн байна. “Сэлэнгэ Алтан намар-2023” үзэсгэлэн худалдаанд 8 иргэн сүү цагаан идээ, оёдол, төмс хүнсний ногоо, даршилсан ногоо зэргээр оролцож 2,785,000 төгрөгийн орлоготой амжилттай оролцлоо.

9 сарын байдлаар 118 иргэн мод бэлтгэх эрхийн бичиг авч 1,449,322 төгрөг, “Тогосын нарс” 302,2м3-аас 6,000,000 төгрөгийн төрийн санд төвлөрүүлсэн байна. Мөн 8 иргэнд загас агнах зөвшөөрөл олгож 190,000 төгрөг, бор гөрөөс 2 тогой 258,000 төгрөг, 1 зэрлэг гахай 280,000 төгрөг, нийт 728,000 төгрөгний зөвшөөрөл олгож ажилласан байна.

#### **Хүдэр сум:**

Үр тарианы дундаж ургац 17цн,төмс 20цн байна.Үр тарианы ургац бороо орж чийг ихтэй байгаа тул хураалт эхлээгүй байна.Төмсний хураалт 10 га хурааснаас 20 тн ургац, хүнсний ногоо хураалт 37 хувьтай байна.

Сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлт 1 иргэний 3,910,100 төгрөг, үндсэн зээл 6 иргэний 75,000 төгрөгийн зээлийн хүү нийт 3,985,100 төгрөгийг төрийн сангийн дансанд төвлөрүүлэв.

МЭНС-2.0 шинэчлэгдсэн, хувилбар 2023 оны 01 сарын 01-ны өдрөөс хэрэгжиж эхэлсэн бөгөөд тайлант сард 59 удаагийн гэрчилгээг цахимаар баталгаажуулж гарган, иргэдэд хөнгөн шуурхай үйлчилгээ үзүүлэн ажиллаа. Үүнд: Адуу 12 толгой, үхэр 73 толгой, хонь 31 толгой, гахай 1 толгой, үхрийн мах 3700 кг, хонины мах 380кг, ямааны мах 30кг, гахайн мах 200кг нийт 4310кг, сүү 25л, хонины ноос 3400кг, тус бүр эрүүл мэндийн гэрчилгээ олгосон байна.

Мал эмнэлгийн Ерөнхий газрын даргын 2023 оны “Бруцеллёзын дархлаажуулалтыг зохион байгуулах тухай” А/179 дүгээр тушаал, аймгийн Засаг даргын 2023 оны А/425, сумын засаг даргын 2023 оны А/115, А/116 дугаар захирамжуудийн хүрээнд мал эмнэлгийн цахим системд бруцеллёз өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад хамрагдах төлөвлөгөөт тарилгын ажилд сумын хэмжээнд адуунаас бусад мал сүргийн охин төлийг бруцеллёз өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтад бүрэн хамруулах ажлыг зохион байгуулж



давхардсан тоогоор 334 өрхийн 2240 толгой тугал, бог малын төл 6400 толгойг бүгд 8640 толгой төл мал хамрагдлаа.

Сумын хэмжээнд хүнс тэжээл хөтөлбөрт 13 өрхийн том хүн 22, хүүхэд 31 нийт 53 иргэнд 576,000 төгрөгийн хүнс тэжээл олгосон байна.

“Сэлэнгэ алтан намар-2023” үзэсгэлэн худалдаанд Хөдөлмөр эхлэлтийг дэмжих сангаас олгож буй Хөгжлийн бэрхшээлтэй иргэнийг дэмжих төсөл хөтөлбөрт хамрагдсан 3 иргэн тус арга хэмжээнд 14 нэр төрлийн бүтээгдэхүүнээр оролцож 1,081,000 /нэг сая наян нэгэн мянган /төгрөгийн борлуулалт хийсэн байна.

2023 онд Хүдэр сумын нутаг дэвсгэрийн хэмжээнд ургасан ойн дагалт нөөцийг судлаж тогтоох ажлаар Ойн анги, болон холбогдох албан хаагчид, Ойн газрын ажлын хэсгийн бүрэлдэхүүн, ойн санг гэрээгээр эзэмшигч нөхөрлөл, аж ахуйн нэгжийн төлөөлөлийг оролцуулан Нуурын тагт, Амж, Хэрц зэрэг 3 чиглэлийн 6 цэгт “Сибирь хушны самрын ургац тодорхойлох аргачлал”-ын дагуу тооллого, хэмжилт хийж үзэхэд сумын хэмжээнд хуш модны самрын нөөц дундаж ургацтай гэсэн дүгнэлт гарч байна.

Хүрээлэн буй орчны эсрэг гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх зорилгоор 9-р сард иргэд, олон нийт, аж ахуйн нэгж байгууллага, нөхөрлөлүүдэд Хүдэр сум ойн анги, цахим хуудсаар дамжуулан хууль дүрэм, журам стандарт, ой хамгаалалын чиглэлээр зөвлөмж мэдээ, мэдээлэл, постерыг 22 удаа оруулж давхардсан тоогоор 496 хүнд хандалт өгч хамрагдсан байна.

#### **Цагааннуур сум:**

Ерөнхий боловсролын сургуулийн 2023-2024 оны хичээлийн жилд 1132 хүүхэд, 1 дүгээр цэцэрлэгт 143 хүүхэд, 2 дугаар цэцэрлэгт 150 хүүхэд хамрагдаж байна.

Аймгийн Гэр бүл хүүхэд, залуучууд, хөгжлийн газрын сэтгэлзүйч нь ЕБС-ийн 6-12 дугаар ангийн сурагчдад "Нөхөрлөл", "Хүүхдийн эрх, үүрэг", цахим болон бусад гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар яриа таниулга хийлээ. Уг үйл ажиллагаанд 490 хүүхдийг хамрууллаа.

9 сарын байдлаар халамжийн сангаас дараах санхүүжилтийг нийт 2452 иргэний 7346,566,900 мянган төгрөг олгоод байна. 9 сарын байдлаар том хүн 45, хүүхэд 59 нийт 104 иргэнд 1192000 мянган төгрөгийн хүнс тэжээлийн дэмжлэг үзүүлээд байна.

Хөдөлмөрийн чиглэлээр ажлын байрыг дэмжих төсөл хөтөлбөрт 2 иргэн нийт 15 сая төгрөгийн зээлд хамрагдсан. 9 сарын байдлаар ажил идэвхтэй хайгчаар 146 иргэн, шинэ ажлын байранд 66 иргэн, зуучлалаар 69 иргэн ejob программд бүртгээд байна.

Сумын орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгөөр 2 дугаар багт шинээр “Гэрэлтүүлэг”-ийн ажлыг “Нарсан цамхаг” ХХК 100 хувийн гүйцэтгэлтэй хүлээлгэн өгсөн. 2, 3 дугаар багийн шороон зам засах ажлыг “Сэлэнгэ-Есөн эрдэнэ” ХХК 100 хувийн гүйцэтгэлтэй, 1 дүгээр цэцэрлэгийн бохирын засварын ажлыг “Тэмжин” ХХК 90 хувь, Хорооллын тоглоомын талбайн тоглоом шинэчлэх, хашаажуулах ажлыг “Азийн баялаг” ХХК 90 хувьтай гүйцэтгэлтэй тус тус байна.

Сумын төсвийн хөрөнгөөр 2 дугаар цэцэрлэгийн сургалтын хэрэглэгдэхүүн нийлүүлэх ажлыг “Шимт боловсрол” ХХК 100 хувь хүлээлгэн өглөө.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжигдэн хэрэгжиж буй сумын төв доторх 1,5 км засмал зам тавих ажлыг “Сэлэнгэ АЗЗА” ХК гүйцэтгэж, ажлын явц 60 хувийн гүйцэтгэлтэй, Эрүүл мэндийн төвийн өргөтгөлийн барилгын ажлыг “Девсофт” ХХК 70 хувийн гүйцэтгэлтэй байна.

Аймгийн хөрөнгө оруулалтаар “Зам засвар, тэмдэг тэмдэглэгээ, замын гэрэлтүүлэг” Сэлэнгэ-Есөн эрдэнэ ХХК 100 хувь, Хонхорт цэвэр усны шугам татаж, ухаалаг худаг гаргах ажлыг “Алтайн үндэс” ХХК 100 хувь гүйцэтгэсэн.

“Сэлэнгэ алтан намар-2023” үзэсгэлэн худалдаанд 6 иргэн 12 төрлөөр амжилттай оролцож нийт 4,257,500 төгрөгийн борлуулалт хийсэн байна.

Сумын 151200 мал амьтаныг вакцинд хамруулахаас 84057 толгой мал амьтан хамруулсан ба гүйцэтгэл 52 хувьтай хамруулсан байна.

**Шаамар сум:**

Цаг агаарын нөхцөлөөс үүдэн Улаан буудайн хураалт 10, тосны ургамал буюу рапсын хураалт 20, байгалийн хадлан тэжээлийн хураалтын ажил 80, төмс хүнсний ногоо 30 хувьтай тус бүр үргэлжилж байна.

“Сэлэнгэ Алтан намар-2023” үзэсгэлэн худалдаанд 8 ногоочин, 2 жижиг дунд үйлдвэрлэл эрхлэгч иргэд, сүү цагаан идээгээр 2 иргэн, зөгийн балаар 2 иргэн, жимс жимсгэнээр 1 иргэн зэрэг нийт 15 иргэн 1 аж ахуйн нэгжийн төлөөлөл оролцсон.

“Намрын ногоон өдрүүд”-улсын чанартай үзэсгэлэн худалдаа 9 дүгээр сарын 20-26-ны өдрүүдэд нийслэл хотод зохион байгуулагдаж, төмс, хүнсний ногоогоор 16 иргэн, зөгийн бүтээгдэхүүнээр 6 иргэн оролцож байна.

9 дүгээр сарын 19-ний өдөр 1, 2 дугаар багуудад эзэнгүй 36 нохой устгалын ажлыг зохион байгуулж, ариутгал халдваргүйтгэл хийлээ.

Иргэний мэдээллийн дагуу Тужийн нарсны байгалийн цогцолборт газрын захирагаатай хамтран Нам даваа,Тэмээн хүзүү зэрэг газруудаар явж хамтарсан хяналт шалгалтын ажлыг зохион байгуулж гарсан зөрчил дутагдлыг арилгасан.

СЭЛЭНГЭ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР